

Хараат бус тайлагнах механизм

Үйл ажиллагааны Үндэсний
төлөвлөгөөний тойм:
Монгол Улс (2023–2027)

Open
Government
Partnership



Independent
Reporting
Mechanism

Агуулга

Хэсэг I: Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн (НЗТ) 2023-2027 оны үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний тойм	2
Хэсэг II: Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2023-2027 оны үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд тусгасан хэрэгжих боломжтой үүрэг амлалт	6
Хэсэг III: Арга зүй, Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-ын шалгуур үзүүлэлт	22
Хавсралт 1: Үүрэг амлалт нэг бүрийн мэдээлэл	26
Хавсралт 2: Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг хамтран бүтээх явц	28

Хэсэг I: Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн (НЗТ) 2023-2027 оны үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний тойм

Монгол Улсын үйл ажиллагааны Үндэсний V төлөвлөгөө нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний чиглэлээр хэрэгжихүйц бодит хууль тогтоомжийг батлан гаргах зорилтыг дэвшүүлжээ. Тус төлөвлөгөө нь төрийн бодлого, үйлчилгээнд оролцооны үнэлгээг нэвтрүүлэх үүрэг амлалтыг мөн тусгажээ. Улмаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үүрэг амлалт нь шинэ 4 жилийн хэрэгжилтийн хугацааг бүрэн ашиглах хэрэгтэй юм. Санхүүгийн болон өндөр түвшний улс төрийн дэмжлэг дутмаг байсан хэдий ч үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг боловсруулах үйл явц нь НЗТ-ийн чиглэлээр төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааг ихээхэн бэхжүүлсэн байна.

Монгол Улсын үйл ажиллагааны үндэсний V төлөвлөгөө нь анх удаа 4 жилийн хэрэгжилтийн хугацаатай (2023 оны 12 дугаар сараас 2027 оны 12 дугаар сар хүртэл) төлөвлөгөө юм. Төлөвлөгөөнд багтсан 9 үүрэг амлалт нь өмнөх төлөвлөгөөнд дурдсан бодлогын чиглэлд шинэчлэлийг үргэлжлүүлэх тодорхой зорилт, хүрэх үе шатыг багтаасан байна. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг боловсруулахад Монгол Улс НЗТ-ийн хамтран бүтээх наад захын шаардлагыг үргэлжлүүлэн хангасаар байна. Монголын НЗТ-ийн Үндэсний зөвлөл нь НЗТ-ийн платформын оролцоо, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор 4 жилийн хугацаатай төлөвлөгөөг эхлүүлэхээр шийдсэн ба хэрэгжилтийг улирал бүр, хагас жил тутамд тайлагнаж, хэрэгжилтээ хянан-шинжлэхээр тусгажээ. Хамтран бүтээх үйл явц өрнөхөөс өмнө, төр болон иргэний нийгмийн удирдагчдын зүгээс өнгөрсөн хугацаанд хүлээлтээс доогуур байсан Монголын НЗТ-ийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний болон түүний хэрэгжилтийн явцын харгалзаж, цаашид хамтын ажиллагааны түвшинг сайжруулах ёстойг онцгойлж байлаа.¹

ТОВЧ ТОЙМ

Оролцож эхэлсэн он: 2013

Үүрэг амлалтын тоо: 9

Үүрэг амлалтын тойм:

Нээлттэй засгийн үнэт зүйлстэй уялдсан үүрэг амлалт: 9 (100%)

Үр дүн гаргах өндөр боломжтой үүрэг амлалт: 2 (22%)

Ирээдүйтэй үүрэг амлалт: 4

Бодлогын чиглэлүүд:

Өмнөх төлөвлөгөөнөөс үргэлжилсэн чиглэл:

- Олборлох үйлдвэрлэл
- Мэдээллийн хүртээмж
- Иргэний эрх, оролцоо
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөө
- Төсвийн ил тод байдал
- Нээлттэй өгөгдөл

НЗТ-ийн хамтран бүтээх наад захын шаардлагад нийцсэн эсэх:

Тийм

Нийтэд нь авч үзвэл ирээдүйтэй шинэтгэл хийхээр төлөвлөсөн 4 үүрэг амлалт байна. Эдгээрээс үр дүн гаргах боломжтой хоёр буюу 1, 4-р үүрэг амлалт нь өмнөх төлөвлөгөөнд туссан олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчныг бэхжүүлэх үүргийг үргэлжлүүлжээ. Хууль тогтоох үйл ажиллагааг бүрэн дуусгахын тулд хууль хэрэгжүүлэгчид хууль тогтоохоос бусад арга хэмжээг анхаарч үзэх шаардлагатай. Мөн 8, 9-р үүрэг амлалт цугтаа төрийн бодлого, үйлчилгээнд хийх оролцооны үнэлгээнд төвлөрч байна. Энэ нь оролцоог хангах эерэг алхам болох ч үүний тогтвортой байдлыг хангах арга хэмжээгээр дамжуулан уг хоёр үүрэг амлалт үр дүнтэй байх боломжийг нэмэгдүүлж болно. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд туссан бусад үүрэг амлалтын хувьд 3, 6, 7-р үүрэг амлалтаа иргэний нийгмийн ил тод байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжийг сайжруулах, нээлттэй өгөгдлийн соёлыг бүрдүүлэх гэж тусгасан нь үр дүн гаргах боломж хязгаарлагдмал байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай 2-р үүрэг амлалт, төсвийн нээлттэй байдлын тухай 5-р үүрэг амлалтын хувьд үр дүн гаргах боломж тодорхойгүй байна. Бодлогын чухал чиглэлд төвлөрч байгаа ч гэсэн 2-р үүрэг амлалт нь бусад үүрэг амлалтын хүрэх үе шатыг давтсан, 5-р үүрэг амлалт нь одоогийн хэрэгжиж байгаа практикаа бодитой сайжруулахаар төлөвлөөгүй байна. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг урт хугацаагаар тодорхойлох давуу талаа бүрэн ашиглаж, хүссэн шигээ тусгаж чадсангүй. Хамгийн ноцтой нь зарим үүрэг амлалт нь 2025 оноос хойш хүрэх үе шат байхгүй байна.

Эдгээр үүрэг амлалтыг хоёр сарын хугацаанд талууд хамтран боловсруулахдаа анх удаа Хүний эрхийг хангах Үндэсний хорооны (ХЭХҮХ) манлайлал дор боловсруулав. Иргэний нийгмийн байгууллагын манлайлагчдын зүгээс олон талын оролцоот хэлэлцүүлэг албан ёсоор эхлүүлэх шаардлагатай хэмээн мэдэгдсэн мөрөөр ХЭХҮХ тус ажлыг эхлүүлж, олон талаас оролцохыг талуудад хандан нээлттэй зарлажээ.² Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 99 тоот тушаалаар Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан төрийн байгууллагын 28 төлөөлөл, төрийн бус байгууллагын 23 төлөөлөөс бүрдсэн бүрэлдэхүүн ажиллажээ. Ажлын хэсгийн төлөөлөл үндсэндээ Улаанбаатар хотоос төвлөрөн бүрдэж, хуралдааныг цахимаар зохион байгуулсан байна. Ажлын хэсэг дээр өмнөх төлөвлөгөөнд багтсан ч бүрэн хэрэгжээгүй 10 үүрэг амлалт, цахим санал асуулгаар дэвшүүлсэн 4 шинэ үүрэг амлалтын талаар хэлэлцжээ. Олон нийттэй зөвлөлдсөний үндсэн дээр Ажлын хэсэг нь 10 санал дээр зөвшилцөн, дараагийн хэлэлцүүлэгт шилжүүлсэн байна. Төрийн байгууллагын 20, төрийн бус байгууллагын 30 төлөөллийн зүгээс ирүүлсэн санад түшиглэн Ажлын хэсэг 9 үүрэг амлалтыг үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд багтааж, улмаар төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 120 тоот тушаалаар баталсан билээ. Эдгээр 9 үүрэг амлалтын дөрвийг (1, 3, 4, 7) иргэний нийгмийг төлөөлсөн оролцогч талууд, гурвыг (6, 8, 9) төрийн байгууллагыг төлөөлсөн оролцогч талууд, хоёрыг (2, 5) талууд хамтран санал болгож төлөвлөгөөнд тусгажээ. Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд тусгаагүй үлдсэн саналуудад байгаль орчин, хог хаягдал, төрийн худалдан авах ажиллагаа, шүүхийн үйлчилгээний хүртээмж, бизнес болон хүний эрхийн чиглэлийн саналд багтжээ.³

ХЭХҮХ нь хамтран бүтээх үйл явцыг илт ахиулан сайжруулж, хэдийгээр санхүүгийн болон өндөр түвшний улс төрийн дэмжлэг хангалтгүй байсан ч Монгол Улсын НЗТ-ийн талбарын хувьд томоохон дэвшил болохуйц алхам хийжээ. Үр дүнтэй хэлэлцүүлэг⁴, Засгийн газрын

манлайлал⁵, ил тод баримтжуулалт⁶ дутмаг байсан өмнөх төлөвлөгөөний мөчлөгтэй харьцуулбал ХЭХҮХ хамтран бүтээх төлөвлөгөөг⁷ бэлтгэн гаргахдаа ХБТМ-ын зүгээс ирүүлсэн удирдамж, зөвлөмжийг хичээнгүйлэн даган мөрдсөн байна. ХЭХҮХ нь хариуцсан байнгын 2 ажилтантай тул НЗТ-ийн хамтран бүтээх үйл явцыг ямар нэгэн тусгайлсан төсөв, нэмэлт ажилтангүйгээр удирдан явуулах, бүтээлчээр хандах шаардлага тулгарч, үүнд зардал багатай цахим оролцоог сонгох эсвэл уулзалтыг төсөвтэй арга хэмжээтэй хамт хийх зэргээр ажиллажээ.⁸ Хамтран бүтээх үйл явцын ил тод байдлыг хангахдаа ХЭХҮХ шинийг санаачилжээ. Хорооны зүгээс хамтран боловсруулах хуралдаан, НЗТ-ийн товч танилцуулгын дүрс бичлэгийг өөрийн Youtube сувагт байршуулсан.⁹ Хамтран бүтээх үйл явц бүрийн дараа хуралдааны тэмдэглэл, дүрс бичлэг, зөвлөлдсөн тэмдэглэл, төлөвлөгөөний төслийн цаг хугацааны дарааллаар оруулах замаар НЗТ-ийн үндэсний вебсайт дээр Англи, Монгол хэлээр мэдээлэл нэг бүрээ шинэчилэн нийтэлж байсан нь мэдээллийн хүртээмжийг сайжруулсан байна.¹⁰ Монгол Улсын үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд олон жилийн туршид оролцсон иргэний нийгмийн төлөөллийн үзэж буйгаар хамтран бүтээх үйл явц нь Ажлын хэсгийн хувьд бүтээлч оролцооны орчныг бүрдүүлж, оролцогч талууд хамтран ажиллах тэгш боломжийг бий болгож, өмнөх төлөвлөгөөтэй харьцуулбал илүү мэдээлэлтэй, оролцоотой болсон гэдгийг дурджээ.¹¹

Улсын Их Хурлын 2024 оны сонгууль, Ерөнхийлөгчийн 2027 оны сонгуулиас өмнө ХЭХҮХ болон Ажлын хэсэг нь үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийг амжилттай хангах хангалттай нөөцтэй байвал зохино. Энэ нь Монгол Улсын хувьд дөрвөн жилээр төлөвлөсөн анхны төлөвлөгөө болохыг харгалзан ХБТМ-ын зүгээс тухайн үүрэг амлалтын үр дүн гаргах боломжийг хангахуйц нэмэлт өөрчлөлт оруулахыг харгалзан үзэхийг зөвлөж байна. Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг ирүүлснээс хойш нэг жилийн дотор¹² эсвэл төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаа дундаа орох үед¹³ төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой юм. Ийнхүү нэмэлт өөрчлөлт оруулснаар төлөвлөгөөнд тусгасан үүрэг амлалтын хүрэх түвшнийг өсгөх эсвэл шинэ үүрэг амлалтыг нэмж тусгах боломжтой.

¹ Б.Болорсайхан, Д.Номинчимэг (Хүний эрхийг хангах Үндэсний хороо), ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 11.

² Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний үйл ажиллагааны 5 дугаар төлөвлөгөө боловсруулахад оролцохыг урьж байна,” (2023 оны 9 дүгээр сарын 15), <https://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/220>.

³ Б.Болорсайхан, Д.Номинчимэг (Хүний эрхийг хангах Үндэсний хороо), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2024 оны 02 дугаар сарын 5, ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцаа, 2024 оны 02 дугаар сарын 02 болон 3 дугаар сарын 11.

⁴ Нээлттэй засгийн түншлэл, “ХБТМ-ын дизайны тайлан: Монгол Улс 2019–2021” (2021 оны 11 дүгээр сарын 03), <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-design-report-2019-2021>.

⁵ Энди МкДевитт (Andy McDevitt), *ХБТМ-ын Үйл ажиллагааны тайлангийн шинжилгээ: Монгол Улс 2021–2023* (Нээлттэй засгийн түншлэл, 2022 оны 7 дугаар сар), <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-review-2021-2023>.

⁶ Нээлттэй засгийн түншлэл, “ХБТМ-ын явцын тайлан: Монгол Улс 2016–2018,” Нээлттэй засгийн түншлэл, 2018 оны 9 дүгээр сарын 18), <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-mid-term-report-2016-2018-year-1>.

⁷ Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “Бидний тухай” (2024 оны 5 дугаар сарын 5-ны байдлаар), <http://irgen-tur.mn/mn/blog/ogp>.

⁸ Б.Болорсайхан, Д.Номинчимэг нартай хийсэн ярилцлага.

⁹ Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “Нээлттэй засгийн түншлэлийн видео” (YouTube, шинэчилсэн 2024 оны 02 дугаар сарын 06), <https://www.youtube.com/playlist?list=PL9fK4h0Z5-gGLocqBzSQg3QJSOlofbfwL>.

Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд Хараат бус тайлагнах механизмаас хүргүүлсэн тойм: Монгол Улс 2023–2027 он

Олон нийтээс санал авахад зориулсан хувилбар: Иш татахыг хориглоно

¹⁰ Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ” [мэдээний вебсайт], (2024 оны 5 дугаар сарын 05-ны байдлаар), <http://irgen-tur.mn/mn/blog/ogp/news>.

¹¹ Ш.Цолмон (ОУИТБС-ын Үндэсний зөвлөл), ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 12; Д.Эрдэнэчимэг (Нээлттэй нийгэм форум), ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 15; Иргэний нийгмийн нэр нь тодорхойгүй төлөөлөл 1, ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2024 оны 3 дугаар сарын 18.

¹² Нээлттэй засгийн түншлэл, *НЭТ-ийн Үндэсний гарын авлага: Оролцогчдод зориулсан дүрэм, чиглэл (OGP National Handbook: Rules & Guidance for Participants v6)* (2024 оны 3 дугаар сар), <https://www.opengovpartnership.org/documents/ogp-national-handbook-rules-and-guidance-for-participants-2022>.

¹³ Шинэчлэх хугацаа гэж 4 жилийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнөөс авсан сургамжаа оролцогч талууд үйл ажиллагаанд тусгах, дараагийн түвшинг үнэлэх, зорилт болон үр дүнг баталгаажуулах арга замыг тодорхойлоход зориулсан хугацаа гэж ойлгоно.

Хэсэг II: Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2023-2027 оны үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд тусгасан хэрэгжих боломжтой үүрэг амлалт

Доорх хэсэгт ХБТМ-ын зүгээс ирээдүйтэй, хамгийн биелэх боломжтой хэмээн үзсэн 4 үүрэг амлалтад шинжилгээ хийсэн болно. Ирээдүйтэй үүрэг амлалт нь оролцогч талууд, эсвэл нийт улс орны хэмжээнд ач холбогдол бүхий бодлогын чиглэлд анхаарч байгаа үүрэг амлалт юм. Эдгээр нь баталгаажуулахуйц, нээлттэй засгийн холбогдох үнэт зүйлстэй уялдсан, үр дүн гаргах, мөн биелэх өндөр боломжтой байх ёстой. Тус тоймын хүрээнд үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний сорилт, боломжийг дүгнэн шинжилж, улмаар суралцах, хэрэгжих явцад хувь нэмэр оруулах зорилгоор зөвлөмжийг гаргадаг.

Хүснэгт 1. Ирээдүйтэй үүрэг амлалт

Ирээдүйтэй үүрэг амлалт
1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг батлуулан хэрэгжүүлэх хүчин чармайлтад үндэслэн тус үүрэг амлалт нь улс төрийн хүсэл эрмэлзлийг бүрдүүлэх, салбарын нэгдсэн мэдээллийн сан байгуулах нөөц эх үүсвэрийг дайчлах, иргэний оролцооны арга хэмжээг хамгаалах, компаний хариуцлагатай уялдуулах, шинэтгэлд зориулсан төсвийн хуваарилалтыг баталгаажуулах зэрэг зорилтыг дэвшүүлжээ.
4. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах: Уг үүрэг амлалт нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг бэхжүүлэх, сэтгүүл зүйн шударга үнэнч байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зорьж байна. Хүний эрхийн хамгааллын үнэлгээгээр орон нутгийн түвшин дэх иргэний болон улс төрийн эрхийн хамгаалалтад байгаа хийдлийг судлан тогтоох юм.
8, 9. Төрийн бодлого, үйлчилгээг оролцооны үнэлгээгээр дүгнэх: Эдгээр бүлэг үүрэг амлалт нь иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулах, олон талын оролцоот хандлагыг ашиглан гарсан үр дүнг төрийн бодлого, үйл ажиллагааг сайжруулахад ашиглахаар төлөвлөсөн билээ.

Үүрэг амлалт 1: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, “Төлсөн авснаа нийтэл” Иргэний нийгмийн эвсэл, ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл.

Үүрэг амлалтын бүрэн тайлбарыг дараах холбоос дээрх 1-р үүрэг амлалтаас үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2023-2027-december>.

Нөхцөл байдал, зорилт

Нээлттэй нийгэм форум, Монголын байгаль хамгаалах сангийн зүгээс санал болгон оруулсан¹ энэхүү үүрэг амлалт нь 2025 он гэхэд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг эцэслэн батлуулсан байх зорилтыг дэвшүүлсэн юм.² Үүний хүрээнд

олборлох үйлдвэрлэлийн салбарын нэгдсэн мэдээллийн сан байгуулах, салбарын ил тод байдлыг хангах чиглэлд хангалттай төсөв хуваарилах үүргийг Засгийн газарт оногдуулах зэрэг үйл ажиллагааг төлөвлөсөн байна.

Монгол Улсын эдийн засагт олборлох үйлдвэрлэлийн салбар нь чухал байр суурь эзэлж байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОҮИТБС) зүгээс тухайн салбар нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 25 хувь, төсвийн орлогын 30 хувь, хөрөнгө оруулалтын 42 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 57 хувь, экспортын 90 хувийг бүрдүүлдэг гэж үзэж байна.³ Хувийн хэвшлээс гадна төрийн зүгээс уул уурхайн чиглэлд үйл ажиллагаа явуулж, төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК болон түүний охин компаниуд уг салбарт ажилладаг. Авлигын түвшин өндөр, ил тод байдлын чиглэлээр авч байгаа арга хэмжээ нь сулаас шалтгаалан Монгол Улс эрдэс баялгийн салбарын үр шимийг бүрэн хэмжээнд хүртэж чадахгүй, улмаар Засгийн газрын өрийн хэмжээ олон тэрбумаар хэмжихэд хүрчээ.⁴ Төрийн зүгээс авлигатай тэмцэх чиглэлээр зарим хууль тогтоомжийг гаргасан ч хэрэгжилт хангалтгүй, өгөгдлийн засаглал уялдаа муутай, өгөгдлийн ил тод байдал бүрэн тогтоогүй тухай U4 Авлигын эсрэг мэдээллийн төвөөс (U4 Anti-Corruption Resource Centre) гаргасан материалд дурджээ.⁵ Нийт 12.8 тэрбум ам.долларын үнэ бүхий нүүрсний хулгайн хэрэг 2022 онд илэрснээр эсэргүүцлийн арга хэмжээ олон хоног үргэлжилж⁶, шинэчлэл хийх шаардлагатайг улам тод томруун харуулав. ОҮИТБС-ын хувьд 2022 онд гэхэд олон талын оролцоотой хяналт суларсан нь нэлээдгүй хүчин зүйлээс хамаарсан ба үүнд Ажлын албаны чиг үүрэг Ерөнхий сайдын Ажлын албанаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) руу шилжсэн, КОВИД-19 цар тахлын улмаас олон тооны хязгаарлалт, хөл хорио тавьсан, үзэл бодлоо илэрхийлэх эрх, төрийн үйл ажиллагааны хүртээмж зэрэг муудсан зэргээс шалтгаалсан гэж үзжээ.⁷

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал нь Монгол Улсад өмнө хэрэгжсэн бүх төлөвлөгөөнд тусгасан сэдэв юм. Эхний хоёр удаагийн үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд тусгасан үүрэг амлалтууд нь олборлох салбарт хийсэн гэрээд болон үйл ажиллагааг ил тод болгох замаар эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг сайжруулжээ.⁸ Дараагийн 3 болон 4 дүгээр үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд тусгасан үүрэг амлалтууд нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд шинэчлэлийг бодитоор хэрэгжүүлж, инстүүцлэхээр ажиллаж эхэлсэн ч энэхүү хуулийн төсөл эцэслэн батлаагүй байна.⁹ Энэ бүхнээс үзвэл ХБТМ-ын зүгээс тухайн үүрэг амлалтууд нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг багахан хэмжээнд нэмэгдүүлсэн ч өгөгдлийг баталгаажуулах, тайлагнах механизмын үр ашигтай байдал, хамаарах мэдээлэл, мэдээллийн сангийн олон нийтийн хүртээмж зэрэг дээр өнөөг хүртэл хийдэлтэй байна.¹⁰ Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний туршид оролцогч талуудын зүгээс хуулийн төслийг эцэслэн батлуулах нь олборлох үйлдвэрлэлийн салбарын шинэтгэлийг хийх гол хүчин зүйл болно хэмээн үзэж байна.

Үр дүнд хүрэх боломж: Өндөр

Монголын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл, Хил хязгааргүй алхам төрийн бус байгууллага (ТББ), Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ зэрэг байгууллагын зүгээс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийг баталснаар авлигатай тэмцэх гол алхам буюу олборлох салбарт ил тод байдлыг бий болгоно хэмээн үзэж байна.¹¹ Энэхүү хуулийн төсөл нь олборлох үйлдвэрлэлийн салбарыг хамарсан нэгдсэн мэдээллийн санг бий болгох эрх

зүйн үндсийг тавих юм. Хуулийн хэрэгжилтийг хангахын тулд тодорхой мэдээллийг өгөгдлийн санд ил тод болгож нийтэлж байх 10 хоног, санд байгаа мэдээллийг шинэчилж байх 5 хоногийн дээд хугацааг энэхүү хуулиар заах юм.¹² Тухайн хуулиас одоогоор хаалттай олборлох салбарын мэдээллийг байнга ил тод нийтэлж байх, автоматжуулсан тайлагналаар дамжуулан эцсийн өмчлөгчийн мэдээллийг хялбаршуулах зэрэг үр дүн хүлээж байна.¹³ Хуулийн төсөл нь гэрээний мэдээлэл, Үндэсний баялгийн сангийн орлого зарлага, төрийн өмчит компаниудын мэдээлэл зэргийг ил тод мэдээлж байх эрх зүйн орчныг сайжруулахаар зорьж байна. Ашигт малтмалын тухай хуулиар төсвөөс хийсэн санхүүжилттэй тэнцэх хэмжээгээр уул уурхайн компаниудад хувь эзэмшихийг Засгийн газарт эрх олгох тохиолдолд л илүү чухал ач холбогдолтой байна.¹⁴ Түүнчлэн компаниудын үүрэг хариуцлагатай холбоотой заалтууд нь хэрэгжилтийн зөв зохистой арга хэмжээг бий болгосон тохиолдолд засаглалыг сайжруулах чиглэлээр чухал алхам болно. Хуулийн төсөл нь мөн олборлох үйлдвэрлэлийн салбарыг засаглах олон нийтийн оролцооны механизмыг инстүүцэлж өгөх юм. Хууль тогтоомж нь ОУИТБС-ын олон улсын стандартыг заавал даган мөрдөх, Ажлын алба болон үйл ажиллагаанд зориулан төсөв хуваарилах, Үндэсний зөвлөл дэх иргэний нийгмийн төлөөллийг албажуулах¹⁵, ОУИТБС-ыг удирдах үүргийг УУХҮЯ-наас Ерөнхий сайдын Ажлын албанд буцаан шилжүүлэх зэрэг заалт тусгажээ.¹⁶ Гол оролцогч талуудын зүгээс эдгээр нь олборлох үйлдвэрлэлийн салбарын санаачилгад үзүүлэх төрийн дэмжлэг буурсан үндсэн шалтгаан хэмээн үзэж байна.¹⁷

Энэхүү үүрэг амлалтын хүрээнд хуулийн төслийг эцэслэн батлуулах тохиромжтой мөчийг тогтоож, үүнийг хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлжээ. Өмнөх төлөвлөгөөний хугацаанд УУХҮЯ-ны зүгээс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, улмаар тухайн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ), Сангийн яам (СаЯ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны төлөөллийг оролцуулсан Ажлын хэсэг дээр хэлэлцэн, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй хэмээн үзжээ.¹⁸ Гэвч төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд Улсын Их Хурал энэхүү хуулийн төслийг хэлэлцэн батлаагүй байна.¹⁹ Төр болон иргэний нийгмийн оролцогч талуудын зүгээс энэхүү хуулийн төслийг хэлэлцэн батлаагүй нь УУХҮЯ-ын зүгээс ач холбогдол өгөөгүй²⁰, мөн нууцлалтай холбоотой асуудлууд байсантай холбон тайлбарлаж байна.²¹ Энэхүү хуулийн төслийг боловсруулах чиг үүргийг 2022 оны 6 дугаар сараас ХЗДХЯ үргэлжлүүлж, төслийг өөрийн вебсайтад нийтлэн, иргэний нийгмийн байгууллагатай зөвлөлдөх, санал авах арга хэмжээг өмнөх үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний хугацаанд хийж гүйцэтгэжээ.²²

Энэ удаагийн төлөвлөгөөний хэрэгжилтийн эхэн үед “ХЗДХЯ нь хамтран ажиллахад нээлттэй” байж, талуудтай зөвлөлдөх, санал солилцох арга хэмжээг эхлүүлсэн болохыг Нээлттэй нийгэм форум байгууллагын зүгээс дурдсан.²³ Оролцогч талуудын хувьд хуулийн төсөл батлагдахгүй удаахрах эрсдэлийг бууруулах, ялангуяа 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа гарч болох улс төрийн шилжилтээс үүдэх эрсдэлийг бууруулах нь чухал юм. Жишээлбэл, ОУИТБС-ын хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Засгийн газрын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулснаар тус хуулийн зорин байгаа шинэтгэлд хүрэхээс өөр зам руу зална.²⁴

Хууль батлагдсаны дараа энэхүү үүрэг амлалтын хүрээнд хурдан хугацаанд хэрэгжилтийг хангахаар төлөвлөж байна. Олборлох үйлдвэрлэлийн салбарын нэгдсэн мэдээллийн санг бий болгохын тулд энэхүү үүрэг амлалтын 2 дугаар хүрэх үе шат нь төрийн захиргааны бүхий л түвшинд зохицуулалтыг хангахыг эрэлхийлжээ. Ингэснээр одоогоор хаалттай

байгаа мэдээллийг цуглуулж олон нийтэд нээлттэй болгох, олон байгууллагын талбарт тархсан мэдээллийг цуглуулан нэгтгэж нээлттэй болгох явцыг сайжруулна. Үүнд олгосон тусгай зөвшөөрөл, нөхөн сэргээсэн газар нутаг, байгаль орчныг хамгаалахад зориулсан зардал, худалдан авалтын болон гэрээний мэдээлэл, газар болон ус ашиглах зөвшөөрөл, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тайлан, олборлосон ашигт малтмал, үйлдвэрлэл, борлуулалт, үнэ, орлого, татвар, ашигт малтмалын нөөцийн төлбөр, хураамж зэрэг олон тооны мэдээлэл багтана.²⁵ Монголын ОУИТБС-ын үзэж байгаагаар тус мэдээллийн санг ОУИТБС-ын Үндэсний зөвлөл хариуцан ажиллах ба УУХҮЯ-ны зүгээс эрдэс баялгийн мэдээлэл, БОАЖЯ-ны зүгээс ус, ой, зэрлэг амьтан, байгалийн ургамлын нөөцийн талаарх мэдээллийг нийлүүлэх юм.²⁶

Үүрэг амлалтын 3 дугаар хүрэх үе шат нь эдгээр ил тод байдлын санаачилгыг дэмжих төсвийн санхүүжилтийг баталгаажуулах талаар тусгасан байна. Монголын ОУИТБС-ын зүгээс энэхүү үйл ажиллагаа нь ОУИТБС-ын тайлагналын механизм, стандартуудыг даган мөрдөхөд тулгарч буй хүний нөөцийн хомсдол, ажлын ачааллыг бууруулах, саад тотгоруудыг арилгахад чиглэнэ хэмээн хүлээлттэй байна.²⁷ Нээлттэй нийгэм форумын зүгээс 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд заасан Ирээдүйн өв сан болон Баялгийн сангаар дамжуулан байгалийн нөөц баялгаас төвлөрсөн орлогыг тэгш, шударга хуваарилах заалтыг хангахад чухал ач холбогдолтой болохыг тэмдэглэсэн.²⁸ УУХҮЯ, ХЗДХЯ-ны төлөөлөл, мөн Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-т хандаж, энэ үүрэг амлалтын талаар тайлбар хүссэн ч ямар нэгэн хариу ирүүлээгүй.²⁹

Боломж, сорилт, хэрэгжилтэд хамаарах зөвлөмж

Монгол Улсын НЗТ-ийн анхны төлөвлөгөө гарснаас хойш 10 жилийн дараа дахин санал болгосон үүрэг амлалт нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах урт хугацааны зорилгод хүрэх боломжтой үүрэг амлалт байна. Олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлын тухай хуулийг батласнаар өмнөх үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд тусгасан олон тооны бие даасан шинэтгэлүүдийг бодитоор хэрэгжүүлэх боломж бүрдэх юм. Эдгээрт гэрээний болон тайлагналын ил тод байдал, оролцооны хяналтын механизм, мэдээллийн ил тод байдал зэрэгт өмнөх төлөвлөгөөний үед зарим ахиц гарсан ч эрх зүйн таатай орчин хомс буйгаас нийцтэй болон тогтвортой байдал дутагдсаар байна.

Гэвч 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээс хамааран улс төрийн шилжилт хийх боломжтой тул энэ нь холбогдох оролцогч талууд эрх зүйн шинэчлэл хийхээс эргэж буцахад хүргэж болно. Улсын Их Хурлын удирдлага солигдохоос үүдэн түргэн арга хэмжээ авахгүй удааширснаар тухайн хуулийн төсөл буцахад хүргэж болно. Тус үүрэг амлалтын хэрэгжилтийг сайжруулахад зориулан ХБТМ-ын зүгээс дараах зөвлөмжийг хүргүүлж байна:

- **Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа мэдээллийн ил тод байдлын талаарх хууль тогтоомжтой нийцүүлэхийн тулд нууцлалын нөлөөллийн үнэлгээ хийх, жишээлбэл, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль гэх мэт. Ийм төрлийн үнэлгээг Канад Улсад хийсэн ба үүний хүрээнд нууцлалтай холбоотой эрсдлийг бууруулах арга замыг тодорхойлон гаргажээ.³⁰**

- **Санал болгож буй хуулийн төслийн зүйл, заалтыг сайжруулах, судлах чиглэлээр хувийн хэвшлийн (төрийн өмчит компанийг оролцуулан) төлөөлөлтэй нягт хамтран зөвлөлдөх.** Хувийн хэвшлийн гол талуудаас үзүүлэх дэмжлэг нь тус хуулийн төслийг Засгийн газрын тэргүүлэх чиглэлд илүү байр суурьтай болгож, Засгийн газар болон Улсын Их Хурлаар батлах боломжит мөчийг бүрдүүлнэ. Уг хандлага нь компаниудын зүгээс дэмжсэн асуудлыг олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, нууцлалын асуудалд сөргөөр нөлөөлөлгүйгээр шийдэхэд Нигер Улсад түлхэц болж өгсөн байна.³¹
- Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг хянахын тулд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцогч талууд уулзан хэлэлцэж байх зорилгоор **одоогийн ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн олон талын оролцоот үйл явцад тулгуурлан өргөжүүлэх.** Салбарын нэгдсэн мэдээллийн сангийн үнэн бодит, найдвартай байдлыг нэмэгдүүлэхийн тулд Үндэсний зөвлөл нь **өгөгдлийн баталгаажуулалт, хуваарьт шинэтгэл хийх иж бүрэн оролцооны механизмыг боловсруулж** болно.
- **Даган мөрдөх түвшин болон шат дарааллаар ялган хариуцлага хүлээх зүйл, заалтыг төлөвлөх.** Эцсийн өмчлөгчийн мэдээллийг гарган өгсөн ч байнгын шинэчлэл хийхгүй компаниуд болон ил тод болгоогүй компаниудад захиргааны, санхүүгийн болон эрүүгийн хариуцлагыг ялгавартай ногдуулж байх. Ийнхүү шаардлагыг даган мөрдөх байдлыг илүүтэй дэмжин урамшуулна.
- **Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын талаар мэдлэг нэмэгдүүлэх үйл ажиллагаа, сургалт зохион байгуулах.** Ийм төрлийн санаачилга нь олон нийт болон сэтгүүлчид түлхүү оролцохыг дэмждэг, жишээлбэл авлига болон хууль бус мөнгөн урсгалыг мөрдөхөд нийтэд нээлттэй мэдээллийг ашиглах боломжтой юм. Словак³² болон Украин³³ Улсын үйл ажиллагааны хүрээнд эдгээрийг НЗТ-тэй холбон өгөх жишиг болохуйц үр дүн гарсан.
- **Салбарын нэгдсэн мэдээллийн санг** салбартай холбоотой авлига, мөнгө угаалт, хээл хахууль, санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах, яллахад **хууль сахиулах байгууллагууд ашиглахыг хөхиүлэн дэмжих.** Жишээлбэл, Индонези Улсад хууль сахиулах байгууллагын ажилтнууд эцсийн өмчлөгчийн бүртгэлийг ашиглах болсон нь мэдлэг нэмэгдүүлэх, мэдээллийн санд олон нийт үнэ төлбөргүй ашиглах шаардлагыг гаргах зэрэг үр дүнд хүрчээ.³⁴

Үүрэг амлалт 4: Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах

Хууль зүй, дотоод хэргийн яам, МОНЦАМЭ агентлаг, Азийн сан, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Монголын хэвлэлийн хүрээлэн, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Нээлттэй нийгэм форум, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв, Сэтгүүл зүйн инновац хөгжлийн Үүр төв.

Үүрэг амлалтын бүрэн тайлбарыг дараах холбоос дээр 4-р үүрэг амлалтаас үзнэ үү:

<https://www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2023-2027-december>.

Нөхцөл байдал, зорилтд

Уг үүрэг амлалт нь Монгол Улсад мэдээлэл олох, түгээх чиглэлээр хэвлэл мэдээллийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэж байна. Тухайн үүрэг амлалт нь өмнөх 2 дугаар болон 4 дүгээр төлөвлөгөөнд тусгасан боловч хэрэгжээгүй, Төрийн болон албаны нууцын тухай

хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах амлалтууд дээр суурилжээ.³⁵ Энэхүү үүрэг амлалт нь дээрх хууль болон Харилцаа холбооны тухай хуульд 2027 он гэхэд нэмэлт, өөрчлөлт оруулах хүчин чармайлтын үргэлжлэл юм. Түүнчлэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын ёс зүйн дүрэм (Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс боловсруулсан)-ийг сайжруулж сэтгүүлчийн халдашгүй байдлыг нэмэгдүүлэх, иргэний эрх чөлөө болон улс төрийн эрхийг хамгаалах тухай НҮБ-ын зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангах³⁶, орон нутгийн түвшинд хүний эрхийн тайлан гаргахаар зорьж байна. Нийтэд нь авч үзвэл тухайн үүрэг амлалт нь өмнөх үүрэг амлалтыг дараагийн түвшинд гаргасан, зөвхөн одоо яригдаж буй хуулийн нэмэлт, өөрчлөлтэд баригдахгүйгээр хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах чухал алхам болжээ. Энэхүү үүрэг амлалтыг Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл, Глоб Интернейшнл төв, Сэтгүүл зүйн инновац, хөгжлийн үүр төв зэрэг байгууллагын зүгээс санал болгон оруулжээ.³⁷

Хил хязгааргүй сэтгүүлчид (RSF) байгууллагын судалснаар хэвлэлийн эрх чөлөө, олон ургалч байдлын зарчим нь хуульд тодорхой хэмжээгээр туссан ч Монгол Улс дахь нэр хүнд гутаахтай холбоотой хууль тогтоомж нь боловсронгуй бус, сэтгүүлчдийг тухайн асуудлаар шүүхэд дуудах боломжтой, улмаар цензуртэй хандахад хүргэхүйц хэмжээнд байна гэж дүгнэжээ.³⁸ Сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг 2023 оны 12 дугаар сард хуурамч мэдээлэл тараасан, гадаадын тусгай албадтай хуйвалдсан гэсэн үндэслэлээр баривчлан, таслан сэргийлэх арга хэмжээ авч, улмаар zarig.mn вебсайтад нэвтрэх хандалтыг хаасан нь энэ чиглэлээр томоохон шинэчлэл хийх шаардлагатайг харуулж байна.³⁹ Сэтгүүлчид (мөн шүгэл үлээгчид) эрх зүйн суурь хамгаалалтгүй нөхцөлд байгаагаас⁴⁰ Монгол Улсад бүртгэсэн бусдын нэр хүндэд халдсан хэргийн талаас илүү нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг байгааг Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллагаас тооцон гаргажээ.⁴¹

Үр дүнд хүрэх боломж: Өндөр

Хуулийн болон бусад арга замыг ашиглан энэхүү үүрэг амлалт нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах асуудлыг огцом сайжруулах боломжтой. Монгол Улсад сэтгүүлчид иргэдэд мэдээлэл түгээх, төрийг хариуцлагатай байлгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд олон тооны сорилттой нүүр тулж байна. Энэхүү үүрэг амлалт нь эрх зүйн нэмэлт өөрчлөлтүүдэд төвлөрөн, Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ) тэргүүлэн тухайн саад тотгоруудыг шийдэх олон талт хандлагаар төлөвлөсөн байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд оруулахаар санал болгож байгаа нэмэлт, өөрчлөлт нь бусдын нэр хүндийг гутаасан хэргээр албадан баривчлах, эх сурвалжийн нэрийг илчлэхийг шаардахаас сэтгүүлч, тэдний эх сурвалжийг хамгаалах зорилготой. Эдгээрийг дагалдан Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. Эрэн сурвалжлах сэтгүүлч нийтлэл гаргасны дараа төрөөс эх сурвалжаа ил болгохыг шаардахад хэрэгт холбогдохгүйн тулд ил болгох нь түгээмэл учир Глоб Интернэшнл төвийн үзэж байгаагаар тухайн нэмэлт, өөрчлөлт нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах чиглэлээр томоохон ахиц дэвшил гаргахаар байна.⁴² Транспэрэнси Интернэшнл байгууллага сэтгүүлчид мөрдөн шалгуулахаас айхгүйгээр төрийн албан тушаалтантай холбоотой асуудлыг эрэн сурвалжлах боломжтой болох тул энэхүү хууль тогтоомж нь авлигатай тэмцэхэд чухал ач холбогдолтой⁴³ хэмээн үзэж байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд оруулахаар санал болгож байгаа өөр нэгэн нэмэлт, өөрчлөлт нь хэвлэл мэдээллийн ил тод байдлыг сайжруулахын тулд хэвлэлийн эцсийн

өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох тогтолцоог нэвтрүүлэх заалт байна. Монголын хэвлэлийн хүрээлэнгийн зүгээс нийт хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшил нь хараат бус байдалд нөлөөлөхүйц буюу улс төрчдийн⁴⁴ мэдэлд төвлөрсөн, хүн амын дөнгөж 5-10 хувь хэвлэл мэдээллийн байгууллагад итгэдэг болохыг⁴⁵ тогтоожээ.

Харилцаа холбооны тухай хуулийн хувьд санал болгож байгаа нэмэлт, өөрчлөлт нь төрөөс мэдээлэл харилцаа холбооны сүлжээг албадан хязгаарлах, үүнд мэдээний вебсайтын хандалтыг хаахад төвлөрсөн байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөний зарчимд үндэслэн тодорхой шалгуурууд гаргаснаар төрөөс хэвлэл мэдээллийн сүлжээг хязгаарлах эрх зүйн үндсийг нь хязгаарлах болно.⁴⁶ Глоб Интернэшнл төвийн зүгээс мэдээний сайтууд, контент үүсгэгч, контент нийлүүлэгчдийн мэдээний агуулгад төрөөс хязгаарлалт хийх хэрээс хэтэрлээ хэмээн үзэж байна.⁴⁷ Иргэний нийгмийн төлөөлөл уг нэмэлт, өөрчлөлтийг чөлөөт хэвлэлд чухал ач холбогдолтой, яллуулах эсвэл хяналтад орох айдасгүйгээр нийгэм, улс төрийн асуудлын талаар хэлэлцэх, шүүмжлэх боломжийг хангана хэмээн цохон тэмдэглэж байв.⁴⁸

Түүнчлэн Төрийн болон албаны нууцын тухай хуульд оруулахаар санал болгож буй нэмэлт, өөрчлөлт, ялангуяа 13 дугаар зүйлийн 13.2 болон 14 дүгээр зүйлийн 14.1 - ийг хүчингүй болгох санал нь сэтгүүлчдэд төрийн мэдээлэлд нэвтрэх бололцоог олгох юм. Тус хуулийн 19 дүгээр зүйл болон Транспэрэнси Интернэшнл байгууллагын үзсэнээр өнөөгийн хууль тогтоомж нь бараг бүхий л мэдээллийг төрийн болон албаны нууцын жагсаалтад хамруулах боломжтой ба ингэснээр авлигын хэргийг сурвалжилсан сэтгүүлчийг мөрдөн шалгах, яллах боломжтой байна.⁴⁹ Сүүлийн жилүүдэд энэхүү нөхцөл байдал чөлөөт хэвлэлд тулгарах томоохон саад тотгор болж ирснийг Монголын сэтгүүлчдийн дунд хийсэн судалгаа харуулж байна. Сэтгүүлчдэд мэдээлэл гарган өгөхөөс татгалзаж байгаа төрийн байгууллагууд нь тухайн мэдээллийг хувь хүний, байгууллагын эсвэл төрийн нууцтай холбон тайлбарлаж байна.⁵⁰ Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь төрийн мэдээлэл авах эрх дээр зөвшөөрөгдөх хязгаарлалт тогтоохыг багасгах юм.

Энэхүү үүрэг амлалтыг төлөвлөхөд оролцсон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл хэлэхдээ Улсын Их Хурал болон улс төрийн намуудын зүгээс дэмжлэг хомс, иргэний нийгмийн үйл ажиллагааны уялдаа муу байснаас үүдэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ хойшилсон талаар дурдсан.⁵¹ Глоб Интернэшнл төв, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Монголын хэвлэлийн хүрээлэн зэрэг голлох оролцогч тал, холбогдох төрийн байгууллагын зүгээс оролцоотой байгаа нь Улсын Их Хурал, улс төрийн намуудын удирдлага хуулийн нэмэлт, өөрчлөлтөд дэмжлэг авах, үр дүнтэй ажилласан кейс болох боломжтой юм.⁵²

Тус үүрэг амлалт нь эрх зүйн орчныг сайжруулахаас бусад арга замыг ашиглан Монгол Улсын хэвлэл мэдээллийн орчны чанарыг сайжруулах боломжтой. Үнэн бодит мэдээлэл түгээж байхыг шаардаж буй олон нийтийн шаардлагыг⁵³ сэтгүүлчдийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт, даган мөрдөлтийг сайжруулах замаар шийдэх боломжтой.⁵⁴ Дотоодын хууль тогтоомжоос гадна салбарын ёс зүйн дүрмийг даган мөрдөх тухай олон улсаас өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь хэвлэл мэдээллийн ил тод байдлыг мөн сайжруулна. Жишээлбэл, ёс зүйн дүрэм нь Олон улсын баримт шалгах сүлжээний дараах ерөнхий зарчмуудыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх (1) нам бус, шударга байх, (2) ил тод байдал, эх сурвалжийн стандарт, (3) санхүүжилт, байгууллагын ил тод байдал, (4) арга зүйн стандарт

болон ил тод байдал, (5) нээлттэй, шударга засан хүмүүжүүлэх бодлоготой.⁵⁵ Эцэст нь орон нутгийн хүний эрхийн тайлан гаргах нь энэхүү үүрэг амлалтын нийтлэг зорилгод үзүүлэх ач холбогдол тодорхойгүй ч эдгээр тайлангаас үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхэд тулгарах хамгийн өндөр эрсдэл хаана байгааг тодорхойлох боломжтой. Энэхүү үүрэг амлалтын талаар тайлбар хүссэн ХБТМ-ын хүсэлтэд ХЗДХЯ хариу өгөөгүй.⁵⁶

Хэрэгжилтийн явцад анхаарах боломж, сорилт, зөвлөмж

Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцын ахиц муу байгааг харгалзан үзэж төрийн байгууллагыг төлөөлөл иргэний нийгмийн нөлөөлөгч, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, шаардлагатай эх үүсвэрийг гаргах, улс төрийн дэмжлэг авах зэрэг чухал ач холбогдолтой байна. ХБТМ-ын зүгээс хэрэгжилтийн хугацаанд дараах зөвлөмжүүдийг хүргүүлж байна:

- **Хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах, хэвлэл мэдээллийн ёс зүйн дүрмийг сайжруулахад хэвлэл мэдээллийн оролцогч талуудыг өргөнөөр оролцуулах.** Үүнд зөвхөн сэтгүүлчдээс гадна хэвлэл мэдээллийн эзэд, хөрөнгө оруулагчид, ажиглагчид, иргэний нийгмийн нөлөөлөгчид, үйлчилгээ ханган нийлүүлэгчид, нийтгэгчид болон мэргэжлийн холбоодыг багтаана. Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 -ийг сэтгүүлчдэд тэгш бус ашиглах эрсдэлийг бууруулахын тулд **хууль сахиулах байгууллагын оролцоог хангах.**
- **Хэвлэл мэдээлэл өөрийн ёс зүйн дүрмийг даган мөрдөхийг дэмжих нэмэлт, өөрчлөлтийг танилцуулах.** Жишээлбэл, оролцогч талууд хараат бус талуудыг (жишээлбэл, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага, академик хүрээлэн гэх мэт) ашиглан **хэвлэл мэдээллийн ёс зүйн гэрчилгээтэй сургалт** хийхэд нөөц хөрөнгө зарцуулах боломжтой. Засгийн газрын зүгээс хэвлэл мэдээллийн ёс зүйг дэмжихэд зориулан нөөц хөрөнгө хуваарилахын зэрэгцээ дүрмийн удирдлага, хэрэгжилтэд ямар нэгэн нөлөөлөл үзүүлдэхгүй байх ёстой. Төрийн хөндлөнгийн оролцоо нь тухайн дүрмийг ашиглан сэтгүүлчдийн эрх чөлөөг хязгаарлах, жишээлбэл тухайн гэрчилгээг аваагүй сэтгүүлчдэд ажлын зөвшөөрөл өгөхгүй зэргээр гуйвуулах боломжтой тул энэ асуудал маш чухал юм.
- **Хэвлэл мэдээллээр гарсан мэдээлэл, сэтгүүл зүйн ёс зүйн асуудлаарх маргааныг шийдэх шүүхийн бус маргаан шийдэх хувилбарыг ашиглах.** Жишээлбэл Индонези Улсад бие даасан Хэвлэлийн зөвлөлийн дэргэдэх гурван шатлалт эвлэрүүлэн зуучлал⁵⁷ бүтэлгүйтсэн тохиолдолд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад хуулийн хариуцлага хүлээлгэдэг. Мөн төрийн байгууллага мэдээлэл ил тод болгох шаардлагыг ханган биелүүлээгүй тохиолдолд бие даасан Мэдээллийн комисс нь маргаан таслах хувилбарт арга замыг хэрэгжүүлдэг.⁵⁸
- Олон улсын зүгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, үг хэлэх болон эвлэлдэн нэгдэх эрхийн мониторинг, үнэлгээг хийхдээ **олон талын оролцоот хандлагыг** баримтлах. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлахаас өмнөх хугацаанд энэ үүрэг амлалтад хамаарах гол оролцогч талуудыг багтаасан Ажлын хэсэг нь яриа хэлэлцүүлгийг албан ёсоор эхлүүлэх орон зайг бүрдүүлж болно.

Бүлэглэсэн 8 болон 9-р үүрэг амлалт: Төрийн байгууллагын бодлого болон үйлчилгээнд оролцооны үнэлгээ хийх

Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд Хараат бус тайлагнах механизмаас хүргүүлсэн тойм: Монгол Улс 2023–2027 он

Олон нийтээс санал авахад зориулсан хувилбар: Иш татахыг хориглоно

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар.

Үүрэг амлалтын бүрэн тайлбарыг дараах холбоос дээрх 8 болон 9-р үүрэг амлалтаас үзнэ үү: <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2023-2027-december>.

Нөхцөл байдал, зорилт

Уг бүлэг үүрэг амлалт нь төрийн бодлого, үйл ажиллагаанд оролцооны үнэлгээ хийхэд чиглэсэн. Эдгээр нь үйл ажиллагааны Үндэсний 3 дугаар төлөвлөгөөнд⁵⁹ дурдсан зорилтуудыг үргэлжлүүлсэн ба энэ удаа илүү өргөн хүрээг хамарч байна. Тодруулбал, 8-р үүрэг амлалт нь төрийн үйлчилгээний чанар, ил тод нээлттэй байдлын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны давтамжийг нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. Хоёр жил тутамд хийгдэх судалгааг 8-р үүрэг амлалтад сар, улирал, хагас жил болон жил тутам хийхээр оруулсан байна. Судалгааны үр дүнгийн мөрөөр Үүрэг амлалт 9-ийн хүрээнд олон талын оролцоотой цаашид үнэлэн дүгнэх мэдээллээр хангах болно. Үүрэг амлалтууд нь хамтдаа төрийн бодлого, үйлчилгээг илүү уялдаатай, тогтвортой, олон нийтийн хэрэгцээнд нийцсэн болгоход чиглэсэн иргэний оролцооны албан ёсны сувгийг бүрдүүлэх боломжтой. Энэхүү үүрэг амлалтыг анхлан санал болгосон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь бусад талууд болох Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Хүний эрх, хөгжил төвтэй хамтран хэрэгжилтийг хангана.⁶⁰

Үр дүнд хүрэх боломж: Дунд

Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг ойрхон давтамжтай хийснээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар бусад төрийн байгууллагад бодлогын хэрэгжилт болон үйлчилгээ хүргэхэд оршин байгаа хийдлийг арилгах боломжийг нээн өгөх юм. Үүний зэрэгцээ судалгааны үр дүнг нарийвчлан судлах, засан залруулах зохистой арга хэмжээг судлан гаргах олон талын оролцоот үйл явц нь эдгээр үйл ажиллагааг чиглүүлэн залах олон нийтийн оролцоог хангах юм.

Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа хийх ажиллагаа нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу олгогдсон үндсэн чиг үүрэг дээр суурилна. Шинээр байгуулсан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (ЗГХХГ)-аас эдгээр хоёр үүрэг амлалтын хэрэгжилтэд манлайлан ажиллах нь ихээхэн чухал байх болно. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд ЗГХХГ 16 яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төлөөлөл, иргэний нийгмийн оролцогч талуудаас бүрдсэн Ажлын хэсгийг байгуулсан нь Үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг яам, агентлаг дээр үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц юм.⁶¹

Олон талын оролцоот хэлэлцүүлэгт иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн төлөөллийг оролцуулж бодлого, үйл ажиллагааг хүргэх үйл явцад онцгойлон төвлөрч буй нь өнөөгийн дотоод хэрэгцээнд ашигладаг үр дүнд суурилсан үнэлгээтэй харьцуулбал илүү эерэг алхам болж байна. Тухайн үүрэг амлалт нь төрийн байгууллага бодлогын хэрэгжилт болон үйлчилгээ хүргэхэд уян хатан байх, шаардлагатай үед өөрчлөх боломж олгох давуу талтай байна. Энэ нь урт хугацаандаа иргэд төрийн бодлого, үйлчилгээний үр шимийг бүрэн хүртэх баталгааг бий болгох юм.

Нийтэд нь авч үзвэл Хүний эрхийг хангах Үндэсний хорооны зүгээс энэхүү бүлэг үүрэг амлалтын хүрээнд хоёр жилд нэг удаа хийдэг иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авдаг

өнөөгийн байдлыг сайжруулж, үр дүнд нь үндэслэн арга хэмжээ авч хэрэгжүүлдэг албан ёсны шат дамжлага байхгүй асуудлыг шийднэ гэсэн хүлээлттэй байна.⁶² Гэвч эдгээр үүрэг амлалтын хүрэх үе шат судалгааны үр дүнг эсвэл Үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг хэрэглэх, заавал биелүүлэх механизмыг баталгаажуулж чадаагүй тул үр дүн хязгаарлагдмал байна. Энэхүү үүрэг амлалтын талаар тайлбар хүссэн ХБТМ-ын хүсэлтэд Хяналт хэрэгжүүлэх газрын зүгээс ямар нэгэн хариу ирүүлээгүй.⁶³

Хэрэгжилтийн явцад анхаарах боломж, сорилт, зөвлөмж

Эдгээр бүлэг үүрэг амлалтыг үр дүнд хүргэхийн тулд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь давтамжтай судалгаа хийх, олон талын оролцоот хэлэлцүүлгийг урт хугацаанд баталгаажуулах хүрэх үе шатыг төлөвлөх шаардлагатай. Хэрэгжүүлэгч талууд Бразил Улсын Засгийн газрын тогтоолоор байгуулсан Бодлогын зөвлөлийн жишээг дурдаж байна. Тус зөвлөл байнгын үйл ажиллагаа явуулдаг⁶⁴ ба өөрийн мандатын хүрээнд төрийн бодлого болон хөтөлбөрийг боловсруулах, гүйцэтгэх, хяналт-шинжилгээ хийх, үнэлэх явцад Үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг хүлээн авдаг байхаар зохицуулсан байдаг.⁶⁵ Монгол Улсын хувьд судалгааны эрх зүйн таатай орчинг бодлого боловсруулахад чиглэсэн олон талын оролцоот хэлэлцүүлэгтэй холбох нь өнөөгийн үйл явцыг ихээхэн хэмжээнд сайжруулах боломжийг олгоно. ХБТМ-ын зүгээс энэхүү бүлэг үүрэг амлалтыг амжилттай хэрэгжүүлэхэд зориулан дараах зөвлөмжийг хүргүүлж байна:

- Бүлэг үүрэг амлалтыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэхийн өмнө Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас төрийн бүх байгууллага, орон нутгийн захиргаанд сургалт хийж, **оролцооны үнэлгээний арга зүйн талаар нэгдмэл ойлголт бий болгож, цаашдын хүлээлтийг оновчтой болгох** хэрэгтэй. Ингэснээр одоо үйл ажиллагаа явуулж буй НЗТ-ийн Ажлын хэсэг болон иргэний нийгмийн сүлжээг хөдөлгөж, утга учиртай оролцоход дэмжлэг туслалцаа шаардлагатай **үйлчилгээ хүрдэггүй, төлөөлөл багатай бүлэгт хүрч** ажиллаж болно.
- Оролцооны үнэлгээг энэхүү үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний хугацаанаас цааш тогтвортой үргэлжлүүлэхийн тулд **олон талын оролцоот хэлэлцүүлгийг инстүүцлэх шаардлагатай**. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд өөрчлөлт оруулан Үндэсний зөвлөлийг шилжүүлэх, мандат, оролцооны журам, хяналт-шинжилгээ, үнэлгээний механизмыг бүрдүүлэх боломжтой. Бүх яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай холбогдох бүтцийг ашиглан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар олон талын оролцоотой хэлэлцүүлгээс гаргасан **зөвлөмжийг тусгах механизмыг албан ёсны болгох** боломжтой. Бразил Улсад хэрэгжүүлсэн ижил төстэй загвар дээр эдгээр алхам нь чухал үүрэг гүйцэтгэсэн байна.⁶⁶
- Судалгааны үр дүнгийн талаар зөвлөлдөх олон талын оролцоотой үйл явц дээр нэмээд **иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг боловсруулахад оролцох боломжийг бүрдүүлэх** хэрэгтэй. Ингэснээр төрийн бодлого болон үйлчилгээнд үнэлгээ хийх бүтэн мөчлөгийн туршид олон нийтийн оролцоог хангах юм. Ялангуяа эдгээр судалгааг боловсруулахад **академик чиглэлийн экспертүүдтэй түншлэх нь** чухал юм, учир нь судалгааны аргачлал шинжлэх ухааны нарийвчлалтай байх, мэдээлэл цуглуулах, оролцогчдыг сонгох, асуумжийн загвар, түгээлт зэрэг дээр хараат бус байдлыг хангах нь чухал ач холбогдолтой.
- Уламжлалт арга хэрэглүүр (жишээлбэл цаасан маягт, утасны дуудлага, биечилсэн ярилцлага гэх мэт) болон цахим платформ (жишээлбэл Засгийн газрын вебсайт,

сошиал сүлжээ, цахим шуудан) ашиглан судалгааны хамрах хүрээг нэмэгдүүлэхийн тулд **олон сувгаар иргэдэд хүрэх стратеги ашиглах** хэрэгтэй. Судалгааг түгээхээс тодорхой хугацааны өмнө урьдчилан зарласнаар давтамжтай хийх судалгааны талаар иргэд мэдээлэлтэй болно.

- Судалгааны үр дүнг **иж бүрнээр баримтжуулан нийтэлж байх**, төрийн байгууллагын **тодорхой үйл ажиллагаа болон/эсвэл шийдвэрийг хянан** Үндэсний зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг баримталсан эсэхийг магадлан шалгаж байх.

Бусад үүрэг амлалт

ХБТМ-ын зүгээс хэрэгжих боломж өндөр хэмээн үзээгүй үүрэг амлалтуудыг дор дурдан тусгасан байна. Энэхүү тоймын хүрээнд эдгээр үүрэг амлалтаас суралцах, хэрэгжүүлэхэд тус нэмэр болох зорилгоор зөвлөмжүүдийг хүргүүлдэг билээ.

Төрийн мэдлийн мэдээллийг www.shilen.gov.mn портал дээр нийтлэх шалгуурыг тодорхой болгох замаар мэдээлэл авах эрх чөлөөг баталгаажуулахыг **2-р үүрэг амлалт** зорьж байна. Хүрэх 1-р үе шат нь иргэд төрийн мэдээлэл хүртээмжийг хэрхэн сайжруулах талаар тодорхой мэдээлэл агуулаагүй байна. Түүнчлэн яам, агентлаг, орон нутгийн хэмжээнд нээлттэй өгөгдлийн ил тод байдлын үнэлгээг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зүгээс үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөө хэрэгжиж эхлэхээс өмнө хийсэн ба энэ үнэлгээгээр ил тод болгох явдал сайн буюу дийлэнх нь 90 хувиас дээш үнэлсэн ба 50 хувиас доош үнэлсэн байгууллага байхгүй байсан.⁶⁷ Хүрэх 2-р үе шат буюу эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын цахим зохицуулалт нь өмнөх төлөвлөгөөний зорилтыг давтсан ч,⁶⁸ НЗТ-ийн үнэт зүйлтэй ямар нэгэн хамааралгүй байна. Хүрэх 3 болон 4-р үе шатын хүрээнд олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын нэгдсэн мэдээллийн сан байгуулах болон салбарын засаглалд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нь 1-р үүрэг амлалтын хүрэх үе шаттай ижил байна. Бодит үр дүн гаргахын тулд энэхүү үүрэг амлалт нь төрийн албан хаагчдад өгөгдлийг өөрсдийн санаачилгаар хэрхэн нээлттэй болгох тухай зааж сургах, бэлэн өгөгдөлд дүн шинжилгээ хийх, ил тод болгох чухал өгөгдлийг тодорхойлох, төрийн өгөгдлийн үнэн зөв байдлыг үнэлэх иргэдийн оролцооны механизмыг бий болгох хэрэгтэй.

Иргэний нийгмийн салбарын чадавч болон ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн **3-р үүрэг амлалт** нь үр дүн гаргах боломж хязгаарлагдмал байна. Хүрэх 1 болон 2-р үе шат нь төр болон иргэний нийгмийн түншлэлийг инстүүцлэх, мөн төрийн бус байгууллага, сан, мэргэжлийн холбоодыг зохицуулж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар иргэний нийгмийн эвслүүдэд техникийн болон хууль зүйн дэмжлэг үзүүлэх юм. Хүрэх 3 болон 4-р үе шат нь төсвийн санхүүжилт авсан иргэний нийгмийн гэрээ, санхүүжилт, хөтөлбөрийг ил тод болгох механизмыг бүрдүүлэх замаар иргэний нийгмийн ил тод байдлыг нэмэгдүүлэхээр заажээ. Гэвч төрийн бус байгууллагын төлөөллийн үзэж буйгаар энэхүү үүрэг амлалтын талаар иргэний нийгэм эерэг бодолтой байгаа хэдий ч Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс хуулийн төслийг тэдэнтэй зөвлөлдөхгүйгээр боловсруулж магад хэмээн зовниж байна. Үүний үр дүнд төрийн хяналтад орох, иргэний нийгмийн хараат бус байдал, эрх чөлөөг сулруулах боломжтой хэмээн санаа зовниж байна. Тус үүрэг амлалтыг хамтран боловсруулах явцад манлайлж оролцох үүрэгтэй тус яамны оролцоо тогтвортой бус байсан нь санаа зовних байдлыг илүү нэмэгдүүлжээ.⁶⁹

Дэлхийн Банкны хэрэгжүүлж буй Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл (MASAM)-ийн хүрээнд хийж байгаа төсвийн ил тод байдлын шинэтгэлийг үргэлжлүүлсэн **5-р үүрэг**

амлалт нь төсвийн төсөл, тодотгол, хөрөнгө оруулалтын төслүүд, гадаадын зээл, тусламжийг ил тод болгон shilendans.gov.mn болон odamis.mof.gov.mn порталууд дээр нийтэлж байх, орон нутгийн төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг өмнөх төлөвлөгөөнд тусгасан үүрэг амлалтыг давтан хэрэгжүүлж байна. Өмнөх үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд туссан үүрэг амлалтын нэгэн адил энэ үүрэг амлалт нь одоогийн нөхцөл байдлаас илүү өргөтгөсөн хэмжээнд эсвэл шинээр төсвийн ил тод байдлыг хангах арга хэмжээг төлөвлөн оруулаагүй байна.⁷⁰ Тиймээс энэхүү үүрэг амлалт нь амжилттай хэрэгжих боломжийн хувьд тодорхойгүй байна. Тухайн үүрэг амлалт нь нээлттэй засгийн үйл ажиллагааг сайжруулахын тулд оролцогч талууд олон нийтийн оролцооны чанарыг сайжруулах хэрэгтэй. Жишээлбэл орон нутгийн төсвийн төслийг гаргах үед төрийн байгууллага зөвхөн иргэдийн саналыг хүлээн авахаас гадна иргэдийн өгсөн саналыг төсөлд хэрхэн хэлэлцэн тусгасан талаар эргэн тайлагнадаг байж болно. Нээлттэй засгийн бодит үр дүнг хангахын тулд Сангийн яамны зүгээс олон нийтийн өгсөн саналыг төсвийн үйл явцад хэрхэн тусгах (мөн хэрхэн бодит ажил болгох) талаар илүү тодорхой болгох эсвэл иргэдийн оролцоот төсвийг Нийгмийн эгэх хариуцлагын төслийн хүрээнд илүү өргөн хүрээнд авч үзэх боломжтой юм. Төсвийн харилцан адилгүй порталуудыг цаашид нэгтгэн нэг болгох, мөн төлөвлөхөөс илүүтэйгээр төсвийн бүхий л үйл явцыг (хэрэгжилт, тайлагнал, аудит) хамарсан цогц арга барилыг хэрэглэх нь үр дүнд хүрэх боломжийг нэмэгдүүлж, төсвийн ил тод байдалд НЗТ хувь нэмэр болж буй нь харагдах юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-д төрийн үйлчилгээ, халамжийн тогтолцоог хүртээмжтэй болгох, холбогдох агентлагтай хамтран бие даан амьдрах чадвартай хувь хүний эрх зүйн тогтолцоо, нөхцөлийг бүрдүүлэх чухал шинэчлэлд **6-р үүрэг амлалт** төвлөрсөн байна. Энэхүү үүрэг амлалтад төрийн үйлчилгээний хэд хэдэн шатлал болох төсвийн хуваарилалт, хэрэгцээний үнэлгээ, дэд бүтэц, эрх зүйн шинэчлэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулсан боловсролын мөн халамжийн тогтолцоог хамаарч байна. Энэхүү үүрэг амлалтыг хэрэгжүүлснээр ХБИ-ийн нийгмийн амьдрал дахь оролцоог нэмэгдүүлэх ч зөвхөн Хүрэх 3 болон 6-р үе шатад бодлого боловсруулахад ХБИ-ийн оролцоог нэмэгдүүлэх, ХБИ-ийн хүртээмжийн хэрэгцээний үнэлгээ хийхэд ИНБ-тай хамтран ажиллахаар заасан байгаа нь НЗТ-ийн үнэ цэнтэй хамааралтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог төрийн үйлчилгээний бүхий л чиглэлд инстүүцлэх нь энэхүү үүрэг амлалт бодит үр дүн гаргах боломжийг нэмэгдүүлнэ.

Нээлттэй өгөгдлийн чиглэлээр өнөөг хүртэл бүрдсэн эрх зүйн орчинд үндэслэсэн **7-р үүрэг амлалт** нь төрийн захиргааны бүхий л шатанд нээлттэй өгөгдлийн стандартыг хэрэгжүүлэх, тус стандартыг ашиглан нээлттэй өгөгдлийн иж бүрэн байдал, чанар, нийцлийг үнэлэх зорилтыг дэвшүүлжээ. Энэхүү үүрэг амлалтыг загварчилахад хувийн хэвшил, иргэд, иргэний нийгмийн зүгээс нээлттэй өгөгдлийг ашиглах нь бага байна гэж тусгасан ч нээлттэй өгөгдөл олон нийтийн хэрэгцээнд хэрхэн үйлчлэх тухай олон нийтийн санал бодлыг цуглуулах сувгийг дурдаагүй байна. Жишээлбэл амлалтыг хэрэгжүүлэх талууд Аргентин Улсын нээлттэй өгөгдлийн туршлагаас суралцаж болох ба үүнд төрийн мэдээллийн хийдлийг иргэд судлан тогтоох оролцооны механизмыг бий болгож, тогтсон шалгуур үзүүлэлтийг баримтлан чанарын үнэлгээ хийдэг туршлага байна.⁷¹ Төрийн байгууллагын ажилчдын зүгээс төрийн өгөгдлийг удирдах чадавх сул байгааг харгалзан энэхүү үүрэг амлалт нь өгөгдлийн менежмент, нээлттэй өгөгдөл, олон нийтэд мэдээллийг ил тод болгох зэрэг чиглэлд чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг мөн багтааж болно.

Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд Хараат бус тайлагнах механизмаас хүргүүлсэн тойм: Монгол Улс 2023–2027 он

Олон нийтээс санал авахад зориулсан хувилбар: Иш татахыг хориглоно

Нийтэд нь үзвэл эдгээр үүрэг амлалт нь бодлогын чухал ач холбогдол бүхий чиглэлээр шинэтгэл хийхээр зорьж буй ч үр дүн гаргах боломжийн хувьд дунд болон тодорхойгүй байдалтай, үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөө 4 жилийн туршид хэрэгжих хугацааны давуу талыг бүрэн ашиглаагүй байна. Эдгээр үүрэг амлалтын зарим хүрэх үе шат нь 2025 оноос хойш үргэлжлэхгүйгээр төлөвлөжээ. Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг 2025 оны сүүлээр шинэчлэх боломжит хугацаанд оролцогч талууд үүрэг амлалтуудын хэрэгжилтийг эргэн харж, үүрэг амлалт нэг бүрийн хэрэгжих хугацаа, хүрэх үе шатыг нэмэх, өргөтгөх, өөрчлөх боломж үүснэ. Оролцогч талууд 5 болон 7-р үүрэг амлалтад шинэ эсвэл өөрчлөн сайжруулсан үйл ажиллагааг инстүүцлэх, 2 болон 3-р үүрэг амлалтад хэрэгжилтийг хянан үзэх олон талын оролцоот үйл явцыг нэвтрүүлэх, 6-р үүрэг амлалтад бусад эмзэг бүлгийн иргэдийг (жишээлбэл орлого багатай ядуу иргэд, шашны, нийгмийн цөөнх, эсвэл алслагдсан хөдөө орон нутагт амьдардаг хүмүүс гэх мэт) нэмэлтээр хамруулах, мөн төрийн шийдвэр гаргалтад оролцох тэдний утга учиртай оролцоог хуулиар үүрэг болгох зэргийг харгалзан үзэж, тусгах боломжтой.

¹ Болорсайхан, Номинчимэг (Хүний эрхийг хангах Үндэсний хороо), ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 11.

² Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах нь (MN0057)” (2024 оны 02 дугаар сарын 11-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0057>.

³ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, “Монгол Улс” (2024 оны 02 дугаар сарын 04-ний байдлаар), <https://eiti.org/countries/mongolia>.

⁴ Иоргелина До Росарио болон Карин Стрехекер (Jorgelina Do Rosario and Karin Strohecker), “ТХЗ-ийг хангахын тулд Монгол Улс уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна – Сангийн сайд” *Ройтерс* (2024 оны 01 дүгээр сарын 09), <https://www.reuters.com/markets/asia/mongolia-needs-mining-investments-ramp-up-meet-gdp-target-finance-minister-2024-01-09>.

⁵ Д.Баяр, “Нүүрсний хулгайн хэрэг: Монгол Улсын стратегийн ач холбогдолтой ашигт малтмалд хамаарах авлига болон шинэчлэл (Corruption and Reform of Mongolia’s Strategic Minerals Governance)” (U4 Авлигын эсрэг мэдээллийн төв, 2024 оны 02 дугаар сарын 27), <https://www.u4.no/publications/the-coal-theft-case-corruption-and-reform-of-mongolias-strategic-minerals-governance>.

⁶ Д.Мөнхчимэг, “Нүүрсний хулгайн авлигын эсрэг тэсгэм хүйтэнд Монгол Улсад болсон эсэргүүцлийн ажиллагаа (Mongolians Brave Bitter Cold to Protest ‘Coal Theft’ Corruption)” *Ройтерс* (2022 оны 12 дугаар сарын 08), <https://www.reuters.com/world/asia-pacific/mongolians-brave-bitter-cold-protest-coal-theft-corruption-2022-12-08>.

⁷ ОУИТБС-ын Олон улсын Ажлын алба, *Монгол улс, 2022 оны Баталгаажуулалтын тайлан* (Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, 2022 оны 7 дугаар сарын 19) х.5–6.

⁸ Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Ашигт малтмал, газрын тос, газрын эрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийн сан байгуулж, олон нийтэд ил тод болгох нь (MN0004)” (2024 оны 02 дугаар сарын 11-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0004>; Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Ус, ашигт малтмал, газрын тос, газар зэрэг нийтийн өмч дээр хийгдсэн хөрөнгө оруулалтын, тогтвортой байдлын болон бүтээгдэхүүн хуваах гэрээний ил тод байдлыг хангах нь (MN0005)” (2024 оны 02 дугаар сарын 11-ний байдлаар),

<https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0005>; Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Нийтийн баялгийг ашиглах гэрээний ил тод байдал (MN0032)” (2024 оны 02 дугаар сарын 11-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0032>; Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Ашигт малтмал ашиглах эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн эздийн мэдээллийн ил тод байдал (MN0033)” (2024 оны 02 дугаар сарын 11-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0033>; Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Компаниудын тусгай зөвшөөрөл, мэдээлэл, үйл ажиллагааг төрийн зүгээс нээлттэй, үр дүнтэй болгох нь (MN0034)” (2024 оны 02 дугаар сарын 11-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0034>.

⁹ Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Эцсийн өмчлөгчийн ил тод байдал (MN0044)” (2024 оны 02 дугаар сарын 11-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0044>; Нээлттэй

засгийн түншлэл, “Олборлох үйлдвэрлэлийн салбарын гэрээний ил тод байдал (MN0045)” (2024 оны 02 дугаар сарын 11-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0045>; Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлын бэхжүүлэх нь (MN0048)” (2024 оны 02 дугаар сарын 06-ны байдлаар),

<https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0048>.

¹⁰ Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Эцсийн өмчлөгчийн ил тод байдал (MN0044).”

¹¹ Ш.Цолмон (Монголын ОУИТБС), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2021 оны 12 дугаар сарын болон 2022 оны 02 дугаар сарын 02; Н.Баярсайхан (Хил хязгааргүй алхам), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2022 оны 02 дугаар сарын 14; Илхам Мохаммед, Мариам Мэтью, Лосана Туйраврави болон Ө.Уранцэцэг, “Ази Номхон далайн бүсийн 2023 оны Авлигын төсөөллийн индекс: Авлигын эсрэг арга хэмжээ хангалтгүйн улмаас бүсийн хэмжээнд зогсонги байна” (Транспаренси Интернейшнл, 2024 оны 01 дүгээр сарын 30),

<https://www.transparency.org/en/news/cpi-2023-asia-pacific-stagnation-due-to-inadequate-anti-corruption-commitments>.

¹² Д.Эрдэнэчимэг (Нээлттэй нийгэм форум), ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 15.

¹³ Энди МкДевитт, *ХБТМ Үйл ажиллагааны төлөвлөгөөний шинжилгээ: Монгол Улс 2021–2023* (Нээлттэй засгийн түншлэл, 2022 оны 7 дугаар сар), <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-review-2021-2023>.

¹⁴ Дашпүрэв, “Нүүрсний хулгайн хэрэг: Монгол Улсын стратегийн эрдэс баялгийн засаглал дахь авлига, шинэтгэл.”

¹⁵ МкДевитт, *ХБТМ-ын Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний шинжилгээ: Монгол Улс 2021–2023*.

¹⁶ Ш.Цолмон (Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл), ХБТМ-ын судлаачийн харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 12.

¹⁷ Ш.Цолмонтой харилцсан захидал харилцаа.

¹⁸ Д.Эрдэнэчимэг (Нээлттэй нийгэм форум), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2023 оны 10 дугаар сарын 5; Монголын ОУИТБС, *Монголын ОУИТБС-ын 2023 оны тайлан: 2023 оны тайлан* (Монголын ОУИТБС-ын Ажлын алба, 2023 оны 12 дугаар сар) х.3, <https://eiti.org/documents/mongolia-2023-annual-progress-report>.

¹⁹ Нээлттэй засгийн түншлэл, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг бэхжүүлэх нь (MN0048).”

²⁰ Д.Эрдэнэчимэгтэй харилцсан захидал харилцаа.

²¹ Ш.Цолмонтой харилцсан захидал харилцаа.

²² Хууль зүй, дотоод хэргийн яам, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл” (2023), <https://mojha.gov.mn/content/651fbaff99e06106c641f63a>.

²³ Д.Эрдэнэчимэгтэй харилцсан захидал харилцаа.

²⁴ Ш.Цолмонтой харилцсан захидал харилцаа.

²⁵ МкДевитт, *ХБТМ-ын Үйл ажиллагааны төлөвлөгөөний шинжилгээ: Монгол Улс 2021–2023*, х.8.

²⁶ Ш.Цолмонтой харилцсан захидал харилцаа.

²⁷ Ш.Цолмонтой харилцсан захидал харилцаа.

²⁸ Д.Эрдэнэчимэгтэй харилцсан захидал харилцаа.

²⁹ ХБТМ-ын зүгээс УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга, АМГТГ-ын дарга, ХЗДХЯ-ны ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч нарт 2024 оны 01 дүгээр сарын 05, 3 дугаар сарын 11 болон 4 дүгээр сарын 26-ны өдөр тус тус цахим шуудангаар хандан тайлбар хүссэн ч ямар нэгэн хариу ирүүлээгүй.

³⁰ Канадын Гадаад хэргийн яам, “Олборлох үйлдвэрлэлийн салбарын компанийн нийгмийн хариуцлагын нууцлалын нөлөөллийн үнэлгээ (CSR)” (Канад.са, 2023 оны 8 дугаар сарын 15),

<https://www.international.gc.ca/transparency-transparence/information-privacy-information-protection/assessment-evaluation/responsibility-responsabilite.aspx?lang=eng>.

³¹ Сара Диксон, “Филиппин: Эцсийн өмчлөгчийн ил тод байдал олборлох салбар болон бусад салбарт үр дүн үзүүлэх 4 арга зам” (Нээлттэй засгийн түншлэл, 2021 оны 4 дүгээр сарын 08),

<https://www.opengovpartnership.org/stories/four-ways-beneficial-ownership-transparency-can-benefit-the-extractive-industries-and-beyond>.

³² Нээлттэй засгийн түншлэл, “Бүгд Найрамдах Словак Улс: Эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах нь (SK0143)” (2024 оны 02 дугаар сарын 21-ний байдлаар),

<https://www.opengovpartnership.org/members/slovak-republic/commitments/SK0143>.

³³ Нээлттэй засгийн түншлэл, “Украйн: Эцсийн өмчлөгчийг баталгаажуулах тогтолцоо (UA0061)” (2024 оны 02 дугаар сарын 21-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/ukraine/commitments/UA0061>.

³⁴ Нээлттэй засгийн түншлэл, “Индонези: Олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн менежмент (ID0092)” (2024 оны 01 дүгээр сарын 31-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/indonesia/commitments/ID0092>.

- ³⁵ Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн таатай орчинг бүрдүүлэх нь (MN0026)” (2024 оны 02 дугаар сарын 19-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0026>; Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь (MN0049)” (2024 оны 02 дугаар сарын 01-ний байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0049>.
- ³⁶ Дараахыг үзнэ үү: Хүний эрхийг хангах Үндэсний хороо, *НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН МЕХАНИЗМЫН ЗӨВЛӨМЖИЙН НЭГТГЭЛ* [Consolidation of the United Nations Human Rights Council’s Recommendations] (2023), <https://irgen-tur.mn/file/download/42>.
- ³⁷ Б.Болорсайхан, Д.Номинчимэг нартай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 11.
- ³⁸ Хил хязгааргүй сэтгүүлчид, “Монгол Улс” (2024 оны 02 дугаар сарын 07-ны байдлаар), <https://rsf.org/en/country/mongolia>.
- ³⁹ Лиам Скот, “Нэртэй сэтгүүлчийг хорьсон нь Монголын хэвлэл мэдээллийн салбарыг доргиож байна” (Америкийн дуу хоолой, 2024 оны 01 дүгээр сарын 05), <https://www.voanews.com/a/jailing-of-high-profile-journalist-shocks-mongolia-s-media-industry/7428962.html>.
- ⁴⁰ Хил хязгааргүй сэтгүүлчид, “Монгол Улс;” Хил хязгааргүй сэтгүүлчид, “НҮБ-ийн Монгол Улсад хийсэн хүний эрхийн хяналт: Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллагын зүгээс Хэвлэлийн эрх чөлөөний шинэтгэл хийхэд талуудыг уриаллаа” (2020 оны 10 дугаар сарын 28), <https://rsf.org/en/un-human-rights-review-mongolia-rsf-urges-members-join-its-call-press-freedom-reforms>.
- ⁴¹ Хил хязгааргүй сэтгүүлчид, “Монгол Улс.”
- ⁴² П.Болдхуяг болон бусад., *Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тайлан 2020* (Глоб Интернейшнл төв, 2021 оны 5 дугаар сарын 03), https://www.gic.mn/public/docs/freedom_report/media_freedom_report_2020_en.pdf.
- ⁴³ Илхам Мохаммед болон бусад, “Ази Номхон далайн бүсийн 2023 оны Авлигын төсөөллийн индекс: Авлигын эсрэг арга хэмжээ хангалтгүйн улмаас бүсийн хэмжээнд зогсонги байна” (Транспаренси Интернейшнл, 2024 оны 01 дүгээр сарын 30) <https://www.transparency.org/en/news/cpi-2023-asia-pacific-stagnation-due-to-inadequate-anti-corruption-commitments>.
- ⁴⁴ Алан Сүүн болон Ришад Пател, “Монгол Улс: Хэвлэл мэдээллийн санхүүжилтийг хуульчлах нь.” (Splice Media, 2022 оны 01 дүгээр сарын 07) <https://www.splicemedia.com/our-work/mongolia-codifying-and-funding-the-media-ecosystem>.
- ⁴⁵ Монголын хэвлэлийн хүрээлэн, “Хэвлэл мэдээллийн эздийн монитор: Монгол Улс 2016, Нийгэм” (2016 оны 12 дугаар сарын 07), <https://mongolia.mom-rsf.org/en/context/society>.
- ⁴⁶ Хүний эрхийг хангах Үндэсний хороо, *Нээлттэй засгийн түншлэл: Монгол Улсын үйл ажиллагааны Үндэсний 5 дугаар төлөвлөгөө 2024-2027* (2023 оны 12 дугаар сарын 27) х.13, 17, https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2024/01/Mongolia_Action-Plan_2023-2027_December.pdf.
- ⁴⁷ Х.Наранжаргал, “Монгол Улсын интернэтийн эрх чөлөө” *FOCUS 91* (Ази-Номхон далайн хүний эрхийн төв, 2018 оны 3 дугаар сар), <https://www.hurights.or.jp/archives/focus/section3/2018/03/internet-freedom-in-mongolia.html>; Глоб Интернейшнл төв, “Ерөнхий сайдын хөрөнгийн тухай мэдээлэл нийтэлсэн Монголын вебсайтыг хаалаа” (IFEX, 2014 оны 7 дугаар сарын 09), <https://ifex.org/mongolian-website-blocked-after-posting-article-about-prime-ministers-property>.
- ⁴⁸ Иргэний нийгмийн нэр нь тодорхойгүй төлөөлөл 2, ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 26.
- ⁴⁹ Хуулийн 19 дүгээр зүйл “Монгол Улс: Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн журмаар шийддэг болж буй хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд халдаж, авлигын эсрэг үйл ажиллагаанд аюул учруулж байна” (2020 оны 4 дүгээр сарын 29), <https://www.article19.org/resources/mongolia-criminalization-of-defamation-is-another-disturbing-attack-on-media-freedom-threatening-anti-corruption-efforts>.
- ⁵⁰ Болдхуяг болон бусад., *Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тайлан 2020*.
- ⁵¹ Иргэний нийгмийн нэр нь тодорхойгүй төлөөлөл 2, захидал харилцаа.
- ⁵² Иргэний нийгмийн нэр нь тодорхойгүй төлөөлөл 2, захидал харилцаа.
- ⁵³ Сүүн болон Пател, “Монгол Улс: Хэвлэл мэдээллийн санхүүжилтийг хуульчлах нь.”
- ⁵⁴ Иргэний нийгмийн нэр нь тодорхойгүй төлөөлөл 2, захидал харилцаа.
- ⁵⁵ Олон улсын баримт шалгах сүлжээ, “Ёс зүйн зарчмуудын дүрмийн зорилго” (Хэвлэл мэдээллийн судалгааны Пойнтерийн хүрээлэн, 2024 оны 02 дугаар сарын 07), <https://ifcncodeofprinciples.poynter.org/know-more/the-commitments-of-the-code-of-principles>.
- ⁵⁶ ХБТМ-ын зүгээс ХЗДХЯ-ны ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгчид цахим шуудангаар хандаж 2024 оны 01 дүгээр сарын 05, 3 дугаар сарын 11, 4 дүгээр сарын 26-ны өдрүүдэд тодруулга хүссэн ч ямар нэгэн хариу ирүүлээгүй.

⁵⁷ Хариуцлагатай сэтгүүл зүй, “Хэвлэл мэдээллийн зөвлөл: Индонези” (2017 оны 8 дугаар сарын 22), <https://accountablejournalism.org/press-councils/Indonesia>.

⁵⁸ Нээлттэй засгийн түншлэл, “Индонези: Нээлттэй засаг: Индонези Улсын туршлага” (2013 оны 02 дугаар сарын 01), <https://www.opengovpartnership.org/stories/open-government-the-indonesian-experience>.

⁵⁹ Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа (MN0041)” (2024 оны 02 дугаар сарын 03-ны байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0041>.

⁶⁰ Б.Болорсайхан, Д.Номинчимэг нартай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 11.

⁶¹ “Төрийн бодлогод хяналт үнэлгээ хийх удирдамжийг дахин боловсруулахад Засгийн газрыг дэмжих нь” Монгол Улсын Үнэлгээний Нийгэмлэг, 2023 оны 8 дугаар сар <https://www.mongolianevaluation.mn/31/nitem>.

⁶² Б.Болорсайхан, Д.Номинчимэг (Хүний эрхийг хангах Үндэсний хороо), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2024 оны 02 дугаар сарын 05.

⁶³ ХБТМ-ын зүгээс Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргад цахим шуудангаар хандаж 2024 оны 01 дүгээр сарын 05, 3 дугаар сарын 11, 4 дүгээр сарын 26-ны өдрүүдэд тодруулга хүссэн ч ямар нэгэн хариу ирүүлээгүй.

⁶⁴ Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхим (Бразил), “Decreto N° 8.243, de 23 de Maio de 2014” [2014 оны 5 дугаар сарын 23-ны 8.243 тоот тогтоол] (2014 оны 5 дугаар сарын 23),

https://www.planalto.gov.br/ccivil_03/_ato2011-2014/2014/decreto/D8243imprensa.htm.

⁶⁵ *Дээрхийн адил.*

⁶⁶ Participedia, “Арга зүй: Төрийн бодлогын зөвлөл (Бразил)” (2024 оны 4 дүгээр сарын 26-ны байдлаар), <https://participedia.net/method/4400>.

⁶⁷ Цахим хөгжил, харилцаа холбооны яам, “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ” (2023 оны 12 дугаар сарын 19-нд үүссэн архив), <https://web.archive.org/web/20231219031812/https://shilen.gov.mn>.

⁶⁸ Нээлттэй засгийн түншлэл, “Монгол Улс: Эмийн үнийн ил тод байдлын журам (MN0054)” (2024 оны 02 дугаар сарын 24-ны байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/mongolia/commitments/MN0054>.

⁶⁹ Иргэний нийгмийн нэр нь тодорхойгүй төлөөлөл 1, ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2024 оны 3 дугаар сарын 18.

⁷⁰ Равио Патра, *Хараат бус тайлагнах механизмын Үр дүнгийн тайлан: Монгол Улс 2021–2023* (Нээлттэй засгийн түншлэл, 2024 оны 3 дугаар сарын 7), https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2024/03/Mongolia_Results-Report_2021–2023_EN.pdf.

⁷¹ Нээлттэй засгийн түншлэл, “Аргентин: Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдэх явц дахь иргэдийн мэдээллийг нээлттэй болгох нь (AR0036)” (2024 оны 02 дугаар сарын 08-ны байдлаар),

<https://www.opengovpartnership.org/members/argentina/commitments/AR0036>; Нээлттэй засгийн түншлэл,

“Аргентин: Ус, ариун цэврийн өгөгдөл мэдээллийг нээлттэй нийтлэх нь (AR0085)” (2024 оны 02 дугаар сарын 08-ны байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/argentina/commitments/AR0085>; Нээлттэй засгийн түншлэл,

“Аргентин: Үндэсний конгрессын өгөгдлийг нээлттэй болгох нь (AR0045)” (2024 оны 02 дугаар сарын 08-ны байдлаар), <https://www.opengovpartnership.org/members/argentina/commitments/AR0045>.

Хэсэг III: Арга зүй, Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-ын шалгуур үзүүлэлт

Энэхүү тоймыг боловсруулах зорилго нь үнэлэн дүгнэх явдал бус юм. Энэ бол үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний үзүүлэлт дээр түргэвчилсэн, хараат бус, техникийн тойм хийж, ХБТМ-ын зүгээс тодорхойлсон давуу тал болон сорилтууд нь хэрэгжилтийн явцыг илүү үр дүнтэй болгоход чиглэсэн мэдээллээр хангах зорилготой билээ. ХБТМ нь үр дүн гаргах хамгийн өндөр боломжтой үүрэг амлалт, тухайн улсын оролцогч талуудын хувьд тэргүүлэх чиглэлийн үүрэг амлалт, тухайн улсын нээлттэй засгийн нөхцөл байдалд тэргүүлэх үүрэгтэй эсвэл эдгээр үзүүлэлтийг хослуулсан үүрэг амлалтыг тодруулан гаргадаг.

Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний туршид ХБТМ-ын зүгээс дараах гурван бүтээгдэхүүнийг бэлтгэн гардаг:

- **Хамтран бүтээх явцын тойм:** ХБТМ-ын өмнөх тайланд дурдсан сургамжуудад үндэслэсэн товч тойм бөгөөд тухайн улсад НЗТ-ийн үйл явц, үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний загварчлал болон сургамжаар дамжуулан дэмжлэг үзүүлдэг тойм юм.
- **Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний тойм:** Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний үзүүлэлт дээр товч шинжилгээ хийж, ХБТМ-ын зүгээс тодорхойлсон давуу тал болон сорилтууд нь хэрэгжилтийн явцыг илүү үр дүнтэй болгоход чиглэсэн мэдээллээр хангах зорилготой тойм болно.
- **Үр дүнгийн тайлан:** Бодлогын түвшний үр дүн болон өөрчлөлт хэрхэн гарсан тухай төвлөрсөн нийт хэрэгжилтийн үнэлгээ юм. Мөн НЗТ-ийн журмын даган мөрдөлтийг шалгаж, эгэх хариуцлага болон урт хугацаанд суралцсан тухай мэдээлэл өгдөг.

Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний тойм дотор ХБТМ нь ирээдүйтэй шинэчлэл, үүрэг амлалтыг тодорхойлон гаргахын тулд шүүн тунгаах болон бүлэглэн нэгтгэх үйл явцыг хэрэгжүүлдэг:

Алхам 1: Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд бичсэн үүрэг амлалтаас шалган батлах боломжтой байдлаар нь судлан үзэх зүйлсийг тодорхойлох.

Алхам 2: Тухайн үүрэг амлалтыг нээлттэй засгийн үнэт зүйлстэй уялдсан эсэхийг тодорхойлох. Эдгээр нь НЗТ-ийн үнэт зүйлсэд нийцэж байна уу?

Алхам 3: Хэрэгжилтийг нь баталгаажуулах боломжтой, нээлттэй засгийн үнэт зүйлстэй уялдан боловсруулсан үүрэг амлалтыг судлан үзэж, тодорхой амлалтуудыг нэгтгэн бүлэглэх шаардлагатай эсэхийг тодорхойлох. Бодлогын ижил зорилтой эсвэл ижил шинэчлэл, бодлогын асуудлыг шийдэхэд хувь нэмэр оруулах үүрэг амлалтуудыг нэгтгэн “бүлэглэх” (кластер) боломжтой. Бүлэглэх үүрэг амлалтыг доорх алхмын дагуу ХБТМ-ын ажилтнууд гүйцэтгэдэг:

- а. Нийтлэг ерөнхий сэдвийг олж тогтоох. Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд сэдвээр нь бүлэглээгүй бол ХБТМ-ын ажилтнууд нь НЗТ-ийн баримталдаг зарчмын дагуу сэдэвчлэн бүлэглэх.

- b. Бодлогын ижил асуудлыг шийдэхээр санал болгож байгаа эсвэл ижил хүрээний бодлого эсвэл Засгийн газрын шинэчлэлийг дэмжиж байгаа үүрэг амлалтыг тодорхойлохын тулд үүрэг амлалтуудын зорилтыг судлан үзэх.
- c. Шаардлагатай бол үүрэг амлалтуудыг бүлэглэх. Үүрэг амлалтыг үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд тодорхой бодлого эсвэл төрийн шинэчлэлийн хүрээнд аль хэдийн тодорхойлсон байж болно.

Алхам 4: Бүлэг эсвэл бие даасан үүрэг амлалтын үр дүн гаргах боломжийг үнэлэх.

Шүүж ялгах нь дотоодын үйл явц билээ. Үүрэг амлалт нэг бүрийн талаарх өгөгдлийг 1-р хавсралтад оруулсан. Түүнчлэн энэхүү бүтээгдэхүүнийг дотоодод хянан үзэх үеэр ХБТМ нь үр дүнгийн үнэн бодит байдлыг баталгаажуулах зорилгоор салбарын мэргэшсэн хүнээр хянуулах (peer review), НЗТ Дэмжих нэгжийн тайлбарыг хэрэгтэй гэж үзвэл хүлээн авах, тухайн улсын оролцогч талуудтай баталгаажуулах ярилцлага хийх, хөндлөнгийн экспертээр хяналт хийлгэх, ХБТМ-ын Хараат бус экспертийн бүлгийн хянан шинжилгээ зэргээр мэдээлэл цуглуулан ажилладаг.

Дээр дурдсанчлан ХБТМ нь энэхүү тойм дээр **гурван гол үзүүлэлтийг** баримталдаг:

I. Баталгаажуулах боломж

- **Тийм, хянан үзэхэд хангалттай нарийвчлалтай:** Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд бичсэн зорилт болон санал болгож байгаа үйл ажиллагаа нь хангалттай тодорхой, хэрэгжилтийг бодитоор үнэлэн баталгаажуулах боломжтой байх.
- **Үгүй, хянан үзэхэд нарийвчилсан бус:** Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд бичсэн зорилт болон санал болгож байгаа үйл ажиллагаа нь хангалттай тодорхой бус, хэрэгжилтийг бодитоор үнэлэн баталгаажуулах боломжгүй байх. Үнэлэн баталгаажуулах боломжгүй үүрэг амлалтыг “тоймлох боломжгүй” хэмээн ангилж, цаашид үнэлгээ хийхгүй.

II. Нээлтэй засгийн үнэт зүйлстэй уялдсан байдал

Нээлтэй засгийн тунхаг болон НЗТ-ийн Засаглалын дүрэмд заасан ил тод байдал, иргэний оролцоо эсвэл төрийн эгэх хариуцлагын үнэт зүйлсэд үүрэг амлалт хамааралтай эсэхийг дараах чиглүүлэх асуултын хүрээнд тодорхойлдог. Үүрэг амлалтыг анхааралтай уншин судалсны үндсэн дээр ХБТМ нь тухайн үүрэг амлалтыг нээлтэй засгийн үнэт зүйлстэй уялдан боловсруулсан эсэхийг юуны түрүүнд тодорхойлно:

- **Тийм/Үгүй:** Үүрэг амлалт нь бодлогын чиглэл, инстүүц эсвэл шийдвэр гаргах үйл явцыг илүү ил тод, оролцоотой, олон нийтийн өмнө эгэх хариуцлагатай байхаар боловсруулсан уу?

ХБТМ нь НЗТ-ийн Засаглалын дүрэмд заасан үнэт зүйлсийг тодорхойлсон байдлаар ашигладаг. Түүнчлэн НЗТ-ийн үнэт зүйл нэг бүрд хамаарах дараах асуултыг ашиглан үүрэг амлалт бүрийг нээлтэй засгийн үнэт зүйлстэй уялдан боловсруулсан эсэхэд дүн шинжилгээ хийнэ:

- **Ил тод байдал:** Засгийн газар нь илүү их мэдээллийг ил тод болгох, мэдээлэл авах эрхийг баталгаажуулах эрх зүйн эсвэл институцын орчныг сайжруулах, олон нийтэд нээлтэй болгож байгаа мэдээллийн чанарыг сайжруулах эсвэл төрийн шийдвэр

гаргах үйл явц болон инстүүцын ил тод байдлыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үү?

- **Иргэний оролцоо:** Засгийн газар нь олон нийтийн зүгээс шийдвэр гаргалтад мэдээлэл өгөх эсвэл нөлөөлөх боломж, шат дараалал эсвэл механизмыг бий болгох эсвэл сайжруулах уу? Засгийн газар нь цөөнх болон хязгаарлагдмал төлөөлөлтэй бүлгийн оролцооны механизмыг бий болгох, боломж бий болгох эсвэл сайжруулах арга хэмжээ авах уу? Засгийн газар нь эвлэлдэн нэгдэх, эвсэл холбоо байгуулах, тайван замаар эсэргүүцэл илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан эрх зүйн орчныг бий болгох уу?
- **Төрийн эгэх хариуцлага:** Засгийн газар нь төрийн албан хаагч өөрийн үйлдэлд хариуцлага хүлээх боломжийг бүрдүүлэх эсвэл сайжруулах уу? Төрийн албан хаагчийн эгэх хариуцлагатай байдлыг хангах эрх зүй, бодлого эсвэл инстүүцын тогтолцоог бүрдүүлэх үү?

III. Үр дүнд хүрэх боломж

Өмнө нь “боломжит үр нөлөөний” үзүүлэлт хэмээн нэрлэдэг байсан одоогийн үзүүлэлтийг НЗТ-ийн оролцогч талуудтай зөвлөлдөн ХБТМ-ын Шинэчилсэн тоймын хүрээнд гарсан саналуудыг үндэслэн өөрчлөлт оруулсан билээ. ХБТМ-ын бүтээгдэхүүний шинэ стратегийн хүрээнд үр дүнд төвлөрөх болсноор энэхүү үзүүлэлтийг өөрчлөн, эхний үнэлгээгээр хүлээж байгаа үр дүнг тогтоож, улмаар хэрэгжүүлсний дараа тухайн хүлээж байгаа үр дүн нь ХБТМ-ын Үр дүнгийн тайланд баталгаажуулах боломжийг тодорхойлон гаргах болжээ. Энэхүү үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний тоймын зорилгын хувьд боломжит үр дүнгийн үнэлгээ нь анхан шатанд нь эрт үнэлгээ тогтоох зорилготой бөгөөд тухайн үүрэг амлалт нь төлөвлөгөөнд бичсэн дагуу утга учиртай үр дүнд хүрэх боломжийг анхаарч үздэгээрээ төрийн зүгээс ямарваа нэгэн бодлого дагнахаас эсрэг байдаг.

Үзүүлэлтүүдийн хамрах шатлалыг дараах байдлаар тодорхойлно:

- **Тодорхой бус:** Өнөөгийн хүчин төгөлдөр хууль тогтоомж, шаардлага болон бодлогын хүрээнд үйл ажиллагааг үргэлжлүүлэх зорилготой, ямар нэгэн үр өгөөж бий болгохгүй эсвэл өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулбал нээлттэй засгийн арга барилыг сайжруулах шинж хомс үүрэг амлалт юм.
- **Дунд (хязгаарлагдмал):** Эерэг боловч үйл явц, ажиллагаа эсвэл бодлогод дагнасан өөрчлөлт гаргах санаачилга ажээ. Тодорхой бодлогын чиглэлийг хамарсан үр дүнгүй эсвэл инстүүцыг хамарсан өөрчлөлт гаргахгүй үүрэг амлалт болно. Жишээлбэл арга хэрэгсэл (вебсайт зэрэг), өгөгдлийг ил болгох, сургалт хийх эсвэл туршилтын төсөл орно.
- **Өндөр:** Бодлогын чиглэл, төрийн салбар эсвэл төр иргэн хоорондын харилцааг зохицуулах тоглоомын дүрмийг өөрчлөхүйц үйл ажиллагаа, бодлого эсвэл инстүүцүүдэд бий болгох. Үүрэг амлалт нь төр заавал мөрдөх болон инстүүцын өөрчлөлтийг авчрахуйц байх.

Энэхүү тойм тайланг ХБТМ-ын зүгээс Рабио Патратай хамтран бэлтгэж, Брэндон Халлоран хөндлөнгийн экспертээр ажиллан, хянан тохиолдуулав. ХБТМ-ын арга зүй, бүтээгдэхүүний чанар, хянах явцыг Хараат бус хөндлөнгийн бүлэг (панел) гүйцэтгэлээ. Дэлгэрэнгүй мэдээллийг НЗТ-ийн вебсайтын ХБТМ-ын Шинжилгээ (IRM Overview) хэсгээс үзнэ үү.¹

Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд Хараат бус тайлагнах механизмаас хүргүүлсэн
тойм: Монгол Улс 2023–2027 он
Олон нийтээс санал авахад зориулсан хувилбар: Иш татахыг хориглоно

¹ Нээлттэй засгийн түншлэл, “Тойм: Хараат бус тайлагнах механизм” (2024 оны 5 дугаар сарын 09-ны байдлаар),
<https://www.opengovpartnership.org/irm-guidance-overview>.

Хавсралт 1: Үүрэг амлалт нэг бүрийн мэдээлэл¹

1-р үүрэг амлалт: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах

- Хянан баталгаажуулах боломжтой эсэх: Тийм
- Нээлттэй засгийн дурангаар тольдон боловсруулсан эсэх? Тийм
- Үр дүнд хүрэх боломж: Өндөр

2-р үүрэг амлалт: Мэдээллийн эрх чөлөөг хамгаалах

- Хянан баталгаажуулах боломжтой эсэх: Тийм
- Нээлттэй засгийн дурангаар тольдон боловсруулсан эсэх? Тийм
- Үр дүнд хүрэх боломж: Тодорхойгүй

3-р үүрэг амлалт: Иргэний эрх, хараат бус иргэний нийгмийг дэмжих

- Хянан баталгаажуулах боломжтой эсэх: Тийм
- Нээлттэй засгийн дурангаар тольдон боловсруулсан эсэх? Тийм
- Үр дүнд хүрэх боломж: Дунд

4-р үүрэг амлалт: Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах

- Хянан баталгаажуулах боломжтой эсэх: Тийм
- Нээлттэй засгийн дурангаар тольдон боловсруулсан эсэх? Тийм
- Үр дүнд хүрэх боломж: Өндөр

5-р үүрэг амлалт: Төсөв боловсруулах явцад оролцоог нэмэгдүүлэх

- Хянан баталгаажуулах боломжтой эсэх: Тийм
- Нээлттэй засгийн дурангаар тольдон боловсруулсан эсэх? Тийм
- Үр дүнд хүрэх боломж: Тодорхойгүй

6-р үүрэг амлалт: Төрийн үйлчилгээний хүртээмжийг боловсронгуй болгох

- Хянан баталгаажуулах боломжтой эсэх: Тийм
- Нээлттэй засгийн дурангаар тольдон боловсруулсан эсэх? Тийм
- Үр дүнд хүрэх боломж: Дунд

7-р үүрэг амлалт: Нээлттэй өгөгдлийн соёлыг бүрдүүлэх

- Хянан баталгаажуулах боломжтой эсэх: Тийм
- Нээлттэй засгийн дурангаар тольдон боловсруулсан эсэх? Тийм
- Үр дүнд хүрэх боломж: Дунд

8-р үүрэг амлалт: Төрийг үнэлэх иргэдийн сэтгэл ханамж

- Хянан баталгаажуулах боломжтой эсэх: Тийм
- Нээлттэй засгийн дурангаар тольдон боловсруулсан эсэх? Тийм
- Энэхүү үүрэг амлалтыг дараах байдлаар бүлэглэн нэгтгэж үзсэн: Төрийн бодлого, үйлчилгээний оролцооны үнэлгээ (8 болон 9-р үүрэг амлалт)

Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд Хараат бус тайлагнах механизмаас хүргүүлсэн тойм: Монгол Улс 2023–2027 он

Олон нийтээс санал авахад зориулсан хувилбар: Иш татахыг хориглоно

- Үр дүнд хүрэх боломж: Дунд

9-р үүрэг амлалт: Захиргааны байгууллагын нээлттэй байдлыг нэмэгдүүлэх

- Хянан баталгаажуулах боломжтой эсэх: Тийм
- Нээлттэй засгийн дурангаар тольдон боловсруулсан эсэх? Тийм
- Энэхүү үүрэг амлалтыг дараах байдлаар бүлэглэн нэгтгэж үзсэн: Төрийн бодлого, үйлчилгээний оролцооны үнэлгээ (8 болон 9-р үүрэг амлалт)
- Үр дүнд хүрэх боломж: Дунд

¹ Редакцын тэмдэглэл:

1. Бүлэглэсэн үүрэг амлалтын хувьд: Үр дүнгийн үнэлгээг үүрэг амлалт нэг бүрээр бус бүлэглэсэн түвшинд хийв.
2. Үүрэг амлалтын нэрийг ойлгомжтой болгох зорилгоор засан сайжруулсан байж болно. Үүрэг амлалтыг бүрэн хэлбэрээр нь дараах холбоосоос үзнэ үү: Хүний эрхийг хангах Үндэсний хороо, Нээлттэй засгийн түншлэл: Монгол Улсын үйл ажиллагааны Үндэсний 5 дугаар төлөвлөгөө 2024-2027 (2023 оны 12 дугаар сарын 27), https://www.opengovpartnership.org/wp-content/uploads/2024/01/Mongolia_Action-Plan_2023-2027_December.pdf.

Хавсралт 2: Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг хамтран бүтээх явц

НЗТ-ийн гишүүн орнуудад 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн НЗТ-ийн Оролцоо, хамтын бүтээлийн стандартыг¹ бүрэн биелүүлэх бүхий л хүчин чармайлтыг гаргах үүрэг хүлээдэг. ХБТМ нь 2022 оноос эхлэн үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөгөө ирүүлсэн улсад шинэчилсэн стандартын дагуу үнэлгээ хийж байна. Доорх 2-р хүснэгтэд үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөө боловсруулах явцад улс орны оролцоо, хамтран бүтээх явц наад захын шаардлагыг ханган биелүүлсэн цар хүрээг тусган харууллаа.

Шинэчилсэн стандартад шударга, ил тод хэлбэрээр алгуур шилжихэд зориулан НЗТ-ийн зүгээс 24 сарын хугацааг олгосон болно. Тиймээс 2023 оны 12 дугаар сарын 31-нээс өмнө боловсруулж хүргүүлсэн үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөнд энэхүү шилжилтийн хугацаа хамаарна. ХБТМ-ын зүгээс улс орнууд нь энэхүү стандарт болон наад захын шаардлагуудыг ханган биелүүлсэн эсэхэд үнэлгээ хийх юм.² Харин 2024 оноос эхлэн үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөгөө гаргасан улсын хувьд наад захын шаардлагуудыг ханган биелүүлээгүй бол НЗТ-ийн үйл явцыг зөрчсөн хэмээн тооцно.

НЗТ-ийн Үндэсний гарын авлагад заасанчлан 4 жилийн хугацаагаар үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байгаа улс орнууд 2 жилийн босгон дээр шинэчлэх үүрэгтэй болохыг анхаарна уу. Энэхүү шинэчлэх үйл явцын үед улс орнууд нь 3.1 болон 4.1 дүгээр наад захын шаардлагуудыг хангах үүрэг хүлээнэ.³ ХБТМ-ын зүгээс шинэчлэх үйл явцад хийх үнэлгээг Үр дүнгийн тайланд тусгана.

Хүснэгт 2. Наад захын шаардлага хангасан байдал

Наад захын шаардлага	Хамтран бүтээх шатанд хангасан эсэх?	Хэрэгжилтийн шатанд хангасан эсэх?
1.1 Хэлэлцүүлгийн орон зай: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр 99 тоот тушаалаар төрийн байгууллагыг төлөөлсөн 28 гишүүн, төрийн бус байгууллагыг төлөөлсөн 24 гишүүн бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын НЗТ-ийн үйл ажиллагааны Үндэсний 5 дугаар төлөвлөгөөг хамтран боловсруулах чиг үүрэгтэйгээр байгуулжээ. НЗТ-ийн Дэмжих нэгжтэй хамтран 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр цахимаар явуулсан танилцуулах семинарын дараа Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа явуулах журмыг олон нийтэд нээлттэй болгосон. ⁴ Нийтэд нь авч үзвэл 2023 оны 11-12 дугаар сард Ажлын хэсэг нийт 6 удаа хуралджээ. ⁵	Тийм	Үр дүнгийн тайланд үнэлнэ

<p>2.1 НЗТ-ийн вебсайт: Монгол Улсын НЗТ-ийн вебсайт irgen-tur.mn/mn/blog/ogp нь олон нийтэд нээлттэй, үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг Англи болон Монгол хэл дээр хамтран бүтээх үйл явцын тойм, оролцсон талуудын иж бүрэн жагсаалтын хамтаар нийтэлсэн байна.⁶</p>	Тийм	Үр дүнгийн тайланд үнэлнэ
<p>2.2 Мэдээллийн сан: НЗТ-ийн мэдээллийн санг Монголын НЗТ-ийн вебсайт болох irgen-tur.mn/mn/blog/ogp дээр байршуулсан. Хамтран бүтээх үйл явцын туршид холбоотой мэдээллийн санг байнга шинэчилж, өмнөх төлөвлөгөөнд ХБТМ-аас гаргасан тайлангууд, өмнөх төлөвлөгөөний баримт бичгүүд, хамтран бүтээх хөтөлбөр, Засгийн газрын өөрийн үнэлгээ, үүрэг амлалтуудыг боловсруулахтай холбоотой мэдээлэл, Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл зэрэг хамаарах баримт бичгийн хамт байршуулсан байна.⁷</p>	Тийм	Үр дүнгийн тайланд үнэлнэ
<p>3.1 Урьдчилсан мэдэгдэл: ХЭХҮХ нь хамтран бүтээх хөтөлбөр болон арга механизмыг Монголын НЗТ-ийн вебсайт дээр 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр болсон Ажлын хэсгийн анхны хуралдаанаас 14 хоногийн өмнө буюу 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байршуулсан.⁸</p>	Тийм	Хамаарахгүй
<p>3.2 Олон нийтэд мэдээлэх: Хамтран бүтээх үйл явц эхлэхээс өмнө буюу 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас сонирхож байгаа талуудад хандан Ажлын хэсэгт орж ажиллах урилгыг, нээлттэйгээр нийтэлсэн.⁹ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Zoom платформ ашиглан цахимаар олон нийтийн форум зохион байгуулан, Ажлын хэсгийн боловсруулсан 9 үүрэг амлалт дээр хэлэлцүүлэг өрнүүлсэн.¹⁰ Олон нийтийн оролцоог цааш нь улам идэвхжүүлэх зорилгоор ХЭХҮХ нь Ажлын хэсгийн уулзалтыг бичлэг хэлбэрт оруулан “НЗТ-ийн танилцуулга” видеог өөрийн Youtube суваг дээр байршуулсан.¹¹</p>	Тийм	Хамаарахгүй
<p>3.3 Эргэх холбооны механизм: ХЭХҮХ-ны зүгээс үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөний төсөлд санал ирүүлэх боломжит олон арга замыг нээсэн, жишээлбэл цахим санал асуулга (2023 он 11 дүгээр сарын 13-17 -ны өдөр), олон нийтийн форум (2023 оны 11 дүгээр сарын 30 -ны өдөр), төр болон иргэний нийгмийн зүгээс санал ирүүлэх хугацаа (2023 оны 11 дүгээр сарын 11-15 -ны өдөр), санал болгож байгаа 9 үүрэг амлалтад Ажлын хэсгийн гишүүдээс санал ирүүлэх хугацаа (2023 оны 12 дугаар сарын 19-21 -ний өдөр).¹² Талуудыг идэвхтэй оролцож, хамтран бүтээх үйл явцад NCHR@cabinet.gov.mn цахим шуудангаар өөрсдийн саналыг ирүүлэхийг урьсан байна.¹³ Иргэний нийгмийн зүгээс ирүүлсэн саналыг хүлээн авч, хамтран бүтээх бүхий л үйл явцын туршид Ажлын хэсгийн хуралдаан дээр хэлэлцжээ.</p>	Тийм	Хамаарахгүй
<p>4.1 Үндэслэл бүхий хариулт: Санал болгосон үүрэг амлалтуудад Ажлын хэсгийн хийсэн хэлэлцүүлэг, саналд</p>	Тийм	Хамаарахгүй

<p>өгсөн хариулт зэргийг хурлын тэмдэглэлээр баримтжуулж, Монголын НЗТ-ийн вебсайт дээр¹⁴ болон видео бичлэг байдлаар ХЭХҮХ-ны Youtube суваг дээр байршуулжээ.¹⁵ Нийтэд нь үзвэл төрийн бус байгууллагын төлөөлөл нь хамтран бүтээх үйл явцад тэдний өгсөн санал, үүнд буцаан өгсөн хариулт зэрэг дээр сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлжээ.¹⁶</p>		
<p>5.1 Ид тод, нээлттэй хэрэгжилт: ХБТМ нь хэрэгжилтийн үр дүнг иргэний нийгмийн оролцогч талуудад танилцуулах уулзалт зохион байгуулсан, Үр дүнгийн тайлан дээр иргэний нийгмийн зүгээс санал өгөх боломжийг хангасан эсэх дээр үнэлгээ хийнэ.</p>	<p>Хамаарахгүй</p>	<p>Үр дүнгийн тайланд үнэлнэ</p>

Хүний нөөц, төсвийн хомсдолтой байсан ч Монгол Улс энэхүү төлөвлөгөөний мөчлөгт бодит амжилт гарган, сайжруулахад түлхэц болсон хэмээн ХБТМ-ын зүгээс үзэж байгаа дараах гурван шалтгааныг тогтоолоо:

- Үндсэн хариуцагч байгууллагын чиг үүргийг 2023 оны 3 дугаар сараас эхлэн хүлээн авснаас хойш ХЭХҮХ нь дотоодод явуулсан үйл явцыг **идэвхтэй манлайлан удирдаж**, НЗТ Дэмжих нэгжтэй үйл ажиллагаагаа уялдуулан, зохицуулж ажиллажээ. Монгол Улсын өмнөх НЗТ-ийн үйл явцад инстүүцын тэмдэглэл байхгүйг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ¹⁷ ХЭХҮХ нь ХБТМ-ын зүгээс өгсөн хамтран бүтээх үйл явцаас өмнө Үндэсний зөвлөлийг дахин идэвхжүүлэн ажиллах зөвлөмжийг даган мөрджээ.
- **Ил тод сонгон шалгаруулалт явуулж тодорхой чиг үүргийг тогтоосноор** Ажлын хэсгийн үйл ажиллагааг дэс дараатай, үр дүнтэй болгохын зэрэгцээ **хамтран бүтээх хөтөлбөр, механизмыг урьдчилан хэвлэн нийтэлсэн нь** оролцогч талуудад хамтран үр дүнтэй бэлдэх хангалттай хугацааг олгон улмаар идэвхтэй оролцох боломжтой болгов.
- Ажлын хэсгийн хурал бүрийн дараа НЗТ-ийн үндэсний вебсайт дээр **товч мэдээлэл байршуулж, байнга шинэчилсэн мэдээлэл өгч** байсан нь **хамтран бүтээх үйл явцыг баримтжуулах**, олон нийтийн хүртээмжийг хангахад дэмжлэг болсон. ХЭХҮХ-ны зүгээс цахимаар асуумж түгээх, олон нийтийн форумыг цахимаар зохион байгуулах, олон нийтийн санал авах цахим шууданг ажиллуулах болон Ажлын хэсгийн хурлын видео, НЗТ-ийн журмын тухай видеог өөрийн YouTube сувагт байрлуулах зэрэг авч хэрэгжүүлсэн санаачилгууд нь **зөвлөлдөх үйл явцыг боловсронгуй болгох, оролцооны боломжийг өргөжүүлэхэд** тэмдэглүүштэй хүчин чармайлт болжээ.

¹ Нээлттэй засгийн түншлэл, “НЗТ-ийн Оролцоо, хамтран боловсруулах стандарт” (2021 оны 11 дүгээр сарын 24), <https://www.opengovpartnership.org/ogp-participation-co-creation-standards>.

² Нээлттэй засгийн түншлэл, “ХБТМ-ын зүгээс минимум шаардлагуудад үнэлгээ хийх гарын авлага” (2022 оны 5 дугаар сарын 31), <https://www.opengovpartnership.org/documents/irm-guidelines-for-the-assessment-of-minimum-requirements>.

³ Нээлттэй засгийн түншлэл, “НЗТ Үндэсний гарын авлага: Оролцооны журам, чиглэл (2024)” (2024 оны 4 дүгээр сарын 11), <https://www.opengovpartnership.org/documents/ogp-national-handbook-rules-and-guidance-for-participants-2022>.

⁴ Монгол Улсын Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “НЗТ-ийн танилцуулах веб семинар” (2023 оны 10 дугаар сарын 25), <http://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/216>.

⁵ Б.Болорсайхан, Д.Номинчимэг (Хүний эрхийг хангах Үндэсний хороо), ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцааг, 2024 оны 02 дугаар сарын 02.

⁶ Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “Үйл ажиллагааны Үндэсний төлөвлөгөөг талууд хамтран боловсрууллаа” (2023 оны 12 дугаар сарын 27), <http://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/239>.

⁷ Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ” [мэдээний вебсайт], (2024 оны 5 дугаар сарын 05-ны байдлаар), <http://irgen-tur.mn/mn/blog/ogp/news>.

⁸ Монгол Улсын Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “НЗТ-ийн танилцуулах веб семинар.”

⁹ Монгол Улсын Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны Үндэсний 5 дугаар төлөвлөгөөг боловсруулахад оролцохыг урьж байна” (2023 оны 9 дүгээр сарын 15), <http://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/220>.

¹⁰ Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “Хэлэлцүүлэгт урьж байна” (2023 оны 11 дүгээр сарын 27), <http://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/228>.

¹¹ Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “Нээлттэй засгийн түншлэлийн видеоны жагсаалт” (YouTube, 2024 оны 02 дугаар сарын 06-нд шинэчилсэн), <https://www.youtube.com/playlist?list=PL9fK4h0Z5-gGLocqBzSQg3QJSOlofbfwL>.

¹² Б.Болорсайхан, Д.Номинчимэг нартай харилцсан захидал харилцаа.

¹³ Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “Хэлэлцүүлэгт урьж байна.”

¹⁴ Монгол Улсын Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “Үйл ажиллагааны Үндэсний 5 дугаар төлөвлөгөөг боловсруулах Нээлттэй засгийн түншлэлийн Ажлын хэсгийн анхны хурал боллоо” (2023 оны 11 дүгээр сарын 08), <http://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/215>.

¹⁵ Хүний эрхийг хангах Үндэсний хороо, “Нээлттэй засгийн түншлэлийн видеоны жагсаалт.”

¹⁶ Ш.Цолмон (ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл), ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 12; Д.Эрдэнэчимэг (Нээлттэй нийгэм хүрээлэн), ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 15; Иргэний нийгмийн нэр тодорхойгүй оролцогч 1, ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2024 оны 3 дугаар сарын 18; Иргэний нийгмийн нэр тодорхойгүй оролцогч 2, ХБТМ-ын судлаачтай харилцсан захидал харилцаа, 2024 оны 3 дугаар сарын 26.

¹⁷ Б.Болорсайхан, Д.Номинчимэг (Хүний эрхийг хангах Үндэсний хороо), ХБТМ-ын судлаачийн хийсэн ярилцлага, 2024 оны 02 дугаар сарын 05.